



# **ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2024 он**



## Агуулга

|                                                                                                                             |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Удиртгал .....                                                                                                              | 3  |
| Нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж.....                                                                                         | 4  |
| Нэг. Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зарчим, хараат<br>бус байдал, үйл ажиллагааны ил тод байдал..... | 11 |
| Хоёр. Олон нийтийн радио телевизийн удирдлага, зохион байгуулалт .....                                                      | 14 |
| Гурав. Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт .....                                                                      | 21 |
| Дөрөв. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого, тавигдах тусгай<br>шаардлага .....                               | 32 |
| Тав. Орон нутгийн олон нийтийн радио, телевиз .....                                                                         | 40 |
| Зургаа. Харьцуулсан судалгаа .....                                                                                          | 41 |
| 1. Их Британи   BBC .....                                                                                                   | 41 |
| 2. Япон Улс   NHK .....                                                                                                     | 50 |
| 3. Бүгд Найрамдах Солонгос Улс   KBS.....                                                                                   | 58 |

## Схем, зураг, хүснэгтийн жагсаалт

|                                                                                                                                                |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| <b>Схем 1.</b> BBC-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, томилгоо .....                                                                            | 47 |
| <b>Схем 2.</b> Удирдах зөвлөлийн дэргэдэх заавал байх хороод (Дүрэмд зааснаар) .....                                                           | 48 |
| <b>Схем 3.</b> NHK-ийн засаглалын зураглал .....                                                                                               | 52 |
| <b>Схем 4.</b> NHK-ийн Хөтөлбөр хариуцсан зөвлөлүүдийн зураглал .....                                                                          | 56 |
| <b>Зураг 1.</b> ОНРТ-ийн 2007-2023 оны нийт орлого /тэрбум.төг/ .....                                                                          | 21 |
| <b>Зураг 2.</b> ОНРТ-ийн санхүүжилтийн эх үүсвэрийн ангиллын 2007-2023 оны нийт<br>орлого дахь эзлэх дүн /тэрбум.төг/ .....                    | 22 |
| <b>Зураг 3.</b> Үйлчилгээний хөлсөөр төвлөрүүлсэн орлогын нийт орлогод эзэлж буй<br>хувь .....                                                 | 22 |
| <b>Зураг 4.</b> Үйл ажиллагааны орлогын нийт орлогод эзэлж буй хувь .....                                                                      | 24 |
| <b>Зураг 5.</b> Улсын төсвийн дэмжлэгийн нийт орлогод эзэлж буй хувь .....                                                                     | 30 |
| <b>Хүснэгт 1</b> - Үндэсний зөвлөлийн одоогийн бүрэлдэхүүний талаарх мэдээлэл<br>2024.12.07-ны өдрийн байдлаар .....                           | 15 |
| <b>Хүснэгт 2</b> - Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд тавьсан<br>Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч өөрчлөн найруулсан хувилбар ..... | 25 |
| <b>Хүснэгт 3</b> - Бусад улсын олон нийтийн телевизүүдийн санхүүжилтийн бүтэц .....                                                            | 30 |
| <b>Хүснэгт 4</b> - 2018 оны ерөнхий рейтинг .....                                                                                              | 36 |
| <b>Хүснэгт 5</b> - 2019 оны ерөнхий рейтинг .....                                                                                              | 37 |
| <b>Хүснэгт 6</b> - 2020 оны ерөнхий рейтинг: .....                                                                                             | 37 |



## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /цаашид “ОНРТтХ гэх”/-ийг баталсан. ОНРТтХ нь 6 бүлэг 36 зүйлтэй бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан ч өнгөрсөн 20 жилийн хугацаанд тус хуульд бие даасан үзэл баримтлалын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаагүй байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурлаас Олон нийтийн, радио, телевиз /Цаашид “ОНРТ” гэх/-ийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нийт 4 удаагийн ажлын хэсгийг байгуулж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байжээ. ОНРТ-ийн хөрөнгө, нөөцийн төлөвлөлт, зарцуулалт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд илэрч байсан нийтлэг зөрчил, дутагдал хэвээр байсан тул Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, улмаар хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх саналыг Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсний дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газар 2022 онд тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж байжээ.

Энэхүү судалгааны зорилго нь дээр дурдсан үнэлгээний тайланд тусгагдаагүй асуудлыг нэмж, захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаврын хүрээнд ОНРТ-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, контентын чанар, агуулга, хүртээмжийг сайжруулах болон үйлчилгээний хөлсийг оновчтой тогтоох санал, зөвлөмжийг тусгаж, гадаад орнуудын харьцуулсан судалгааг дэлгэрүүлэн судалж, хуулийн хэрэгжилтийн одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлийг судалж, цаашид хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “4.1.2. Хэвлэлийн эрх чөлөө”: 4.1.2.2-т “Олон нийтийн радио, телевизийн бие даасан байдлыг хангах, хариуцлагатай, хараат бус, иргэдийг соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлоготой болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэчилнэ” гэж тусгажээ.

Судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан эрх зүйн баримт бичиг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хувийн хэрэг, холбогдох бусад эх сурвалж, хуулийн этгээдийн төлөөлөлтэй уулзалт-ярилцлага зохион байгуулах, Английн BBC, Японы NHK, БНСУ-ын KBS зэрэг олон нийтийн телевизийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах замаар гүйцэтгэлээ.



## НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

### ***Нэг.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилт, орхигдсон зохицуулалтын хүрээнд***

1.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18.2-т “Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасан боловч энэ зохицуулалт өнгөрсөн хугацаанд огт хэрэгжээгүй байна.

Засгийн газрын 2000 оны 28 дугаар тогтоол нь нэгдүгээрт, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдахаас 5 жилийн өмнө гарсан, хоёрдугаарт, энэ тогтоолоор “үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоогоогүй” харин “Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам”-ыг л баталжээ. Харин энэ журмын дагуу Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын /хуучнаар/ даргын 2001 оны 403 дугаар тушаалаар олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлсийг тогтоосон байна.

Захиргааны ерөнхий хуулийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж заасан. Гэтэл Засгийн газрын 2000 оны 28 дугаар тогтоол нь ямар нэгэн хуульд үндэслээгүй, уг тогтоолыг үндэслэж гарсан олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлс тогтоосон Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын /хуучнаар/ даргын 2001 оны 403 дугаар тушаал нь үйлчлэл байнга давтагдах, нийтээр дагаж мөрдөх шинжтэй эрх зүйн акт болохынхоо хувьд захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгаа нь уг шийдвэрийн хүчин төгөлдөр байдалд эргэлзээ үүсгэж байна. Энд Захиргааны ерөнхий хуулийн 67.2-т - Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн 67.1-д заасны дагуу нийтэлснээр хүчин төгөлдөр болно. ...”, 67.3-т -Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй”, 67.4-т “Хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг захиргааны хэм хэмжээний акт гаргасан хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хариуцна” гэж заасныг дурдах нь зүйтэй байна.

Иймд олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хураамжийг Захиргааны ерөнхий хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг хэрэгжүүлж байдлаар тогтоох шаардлагатай.

2.ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ “түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газарт тус тус санал болгох”-оор заасан.

Дээр дурдсан мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд хэрхэн нэр дэвшигчийг санал болгож байгаа процесс, хэдээс дээш төрийн бус



байгууллагууд нэгдэж нэр дэвшигчийг тодруулах асуудал нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулагдаагүй, тодорхой бус байна. Үндэсний зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлсэн, томилж байгаа талаарх УИХ-ын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс харахад санал болгож буй субъект нь “төрийн бус байгууллагаас санал болгосон” гэж л танилцуулгад дурдаж байгаа болохоос биш хэдэн төрийн бус байгууллага нэгдэж, хэзээ, хэрхэн яаж нэр дэвшүүлэхээр санал болгож буй процесс байхгүй байна.

Харин Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох томилгоо нь олон улсын жишигт нийцсэн мэт харагдаж байгаа боловч анхан шатны нэр дэвшүүлэх ажиллагааны процесс хуульчлагдаж чадаагүй нь ОНРТ “...үйл ажиллагаандаа хараат бус байх, ... ил тод байдлыг эрхэмлэх, нийт үндэсний эрх ашгийг дээдлэх зарчим баримтлах” гэж заасантай зөрчилдөхөд хүргэж байна. Иймд ОНРТХ-д Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газарт томилуулахаар санал болгож байгаа Үндэсний зөвлөлийн гишүүнийг анхан шатнаас нэр дэвшүүлж байгаа төрийн бус байгууллагуудын оролцооны асуудлыг хуульд тодорхой тусгах шаардлагатай.

Түүнчлэн, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, зөрчсөн, хэрэгжих боломжгүй шийдвэр гаргасан, хуралдааны идэвх оролцооноос үл хамаарч урамшууллыг тогтмол авах зэргээр холбогдох хууль болон журамд заасан эрх, үүргээ зөрчсөн Үндэсний зөвлөлийн гишүүдэд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Санал: Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрх дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хорооноос Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх. Гишүүнд тавих шаардлага хангасан хүний нэрийг иргэний нийгмийн төлөөлөл сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор гаргах байдлаар тусгах.

Санал: Үндэсний зөвлөлийн гишүүдийг холбогдох хуульд нийцүүлж, нэр дэвшсэн салбарын чиглэлээр нь ажлын туршлага, мэргэжил болон мэргэжлийн шаардлагад нийцүүлж нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Санал: “Үндэсний зөвлөлийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй.” гэсний “6 сараас” гэснийг “3 сараас” гэж хугацааг богино болгох шаардлагатай. Ингэснээр Үндэсний зөвлөлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

**3. Үндэсний зөвлөлд хяналт тавьж ажиллах** Хяналтын зөвлөлийн ажиллах нөхцөл, бүрэн эрхийг ОНРТХийн 28, 29 дүгээр зүйлд зохицуулсан бөгөөд хяналтын зөвлөл нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Үндэсний зөвлөлийн 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-аар зохицуулж байна. Энэхүү журмын дагуу Хяналтын зөвлөлийн нэг гишүүнийг Үндэсний зөвлөлийн гишүүд дотроос, хоёр гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, нийт гишүүдийг Үндэсний зөвлөлийн нууц санал хураалтаар сонгож, томилж байна.

Хяналтын зөвлөл нь “хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг эгүүлэн татах тухай зөвлөмж гаргах эрхтэй” байхаар



хуульчилсан. Харин хууль батлагдсан цагаас хойш Хяналтын зөвлөлөөс энэ талаарх зөвлөмж гаргасан тохиолдол байхгүй байна. Учир нь томилж байгаа этгээдээ томилогдож байгаа субъект өөрөө хянах нь зүйд нийцэхгүй бөгөөд энэхүү эрх зүйн зохицуулалт нь практик дээр хэрэгжих боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Иймд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах, тэднийг хариуцлагатай байлгах үүднээс хяналтын зөвлөлийг Үндэсний зөвлөлөөс хараат бусаар томилогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Санал: Хяналтын зөвлөлд Үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгохыг хориглох.

**Хоёр.Олон нийтийн радио, телевизийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд:**

1.Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2021-2023 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланд Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийн бодлогод хэрэгжилт тавих, техник, технологийн сүлжээг хөгжүүлэх, техник хангамжийн бодлогыг тодорхойлох, санхүү, эдийн засгийн чадавхыг сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох зэрэг шийдэл хүлээсэн арга хэмжээнүүдийг тухай бүр нь хэлэлцэж шийдвэрлээгүйгээс байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, хяналт тавих нэгжүүдийн бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлоогүйгээс тэдгээрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнд хүрэхгүй байна гэжээ.

Иймд Монголын Үндэсний радио, телевизийн стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулж хэрэгжилтийг нь тайлагнах. Хүний нөөцийн удирдлагын байгууллагын батлагдсан орон тоо, бүтцэд нийцүүлж хэрэгжүүлэх, удирдах түвшний албан хаагчдыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилох, ажлын цаг ашиглалт, бүртгэлд хяналт тавих, бодит гүйцэтгэлд үндэслэн цалин урамшууллын олгож байх, хөтөлбөрийн бодлогыг хараат бусаар хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, хуульд заасан нэвтрүүлгийн чиглэлүүдийг тэнцвэртэй байхаар төлөвлөх, зар сурталчилгааг хуулиар тогтоосон хэмжээнээс нь хэтрүүлэхгүй байх, реклам зар сурталчилгаа, захиалгат нэвтрүүлгийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг боловсронгуй болгох, түүнд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж сайжруулах шаардлагатай.

2.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар олон нийтийн радио, телевизийг “арилжааны зар сурталчилгаа” явуулахыг хориглосон ч бодит байдал дээр “арилжааны зар сурталчилгаа” явуулж орлого олж байна. Хэрэв, олон нийтийн радио, телевиз нь зөвхөн “нийгмийн зар сурталчилгаа” явуулах ёстой гэж үзвэл, уг зар сурталчилгаанд хугацааны хязгаарлалт байх шаардлагатай юу гэдэг асуудал үүснэ. Гэтэл Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13.3-т “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна” гэж заасан нь зөрчилтэй байдлыг үүсгэжээ. Учир нь хувийн хэвшлийн өргөн нэвтрүүлгийн телевизүүд “нийгмийн зар сурталчилгаа” явуулахад хугацааны шаардлага байхгүй байна.

Иймд олон нийтийн радио, телевизийн арилжааны зар сурталчилгаа явуулж орлого олох зохицуулалтыг боловсронгуй болгох буюу ийм төрлийн зар сурталчилгаа явуулах эсэхийг нэг мөр болгох шаардлагатай. Хэрэв олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлсний хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд тэр





хэмжээгээр арилжааны зар сурталчилгаа явуулж орлого олох хэрэгцээ, шаардлага багасаж хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл байдал үүсэх боломжтой.

**3.ОНРТ-ийн хөтөлбөрийн чанар, агуулга, хүртээмжийг сайжруулах чиглэлээр** олон улсад амжилттай хэрэгжсэн сайн туршлагуудыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Тухайлбал, олон нийтэд сонирхолтой, контент бүтээх, үзэгчдийн сонирхол, шаардлага, хандлагыг судлан, ямар төрлийн контент тэдэнд таалагддаг болохыг тодорхойлох. Энэ нь судалгааны тайлан, санал асуулга, нийгмийн медиа анализ санаа, хэлбэр, зэргээр контентыг баяжуулахад анхаарах шаардлагатай.

**4.ОНРТ-ийн тухайд Ерөнхий захирал ОНРТ-Х-иар тодорхойлсон** хөтөлбөрийн бодлогын хүрээнд нэвтрүүлгийн хөтөлбөрийг тогтоох бүрэн эрхийг эдэлж байгаа бөгөөд цаашид Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар тодорхойлсон ижил зарчмаар буюу хөтөлбөрийн тавигдах шаардлага, бүтцийн хувь хэмжээг хуулийн зарчимд нийцүүлэн нарийвчлан тодорхойлох, хяналт тавих талаар холбогдох журмыг батлах эрхийг Үндэсний зөвлөлд олгож, Ерөнхий захирал нь уг журмын хүрээнд хөтөлбөр, нэвтрүүлэг, контент гаргах байдлаар зохицуулах нь оновчтой байж болох юм.

***Гурав.Олон нийтийн радио, телевизийн контентын чанар, агуулга, хүртээмжийг сайжруулахад эрх зүйн зохицуулалт, түүний зөвлөмжийн хүрээнд***

“ОНРТ-ийн хөтөлбөрийн бодлого, тавигдах тусгай шаардлага”-д дурдсанаар ОНРТ-ийн үзэлтийн хандалт өндөр үзүүлэлттэй байгаа боловч ОНРТ-ээс хүргэж буй хөтөлбөрөөс мэдээ, мэдээлэл, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Үндэсний баяр наадмын хөтөлбөр, олон ангит болон нэг ангит кино, түүх, соёл, ёс заншилтай холбоотой нэвтрүүлгийг зонхилох хувийг эзэлж байна. Түүнчлэн ОНРТ-ийн 1-р суваг буюу MNB-ээс бусад сувгийн хандалт бага, харьцангуй шинэ сувгууд тул үйл ажиллагаа нь жигдрээгүй байгааг харгалзан үзэж бусад улсын сайн туршлага, зохицуулалтыг харьцуулан судлах замаар хөтөлбөрийн хүртээмжийг сайжруулах боломжтой юм.

ОНРТ-ийн хөтөлбөрийн чанар, агуулга, хүртээмжийг сайжруулах чиглэлээр олон улсад амжилттай хэрэгжсэн дараах сайн туршлагуудыг танилцуулж байна. Үүнд:

| Улс        | Байгууллага      | Шилдэг туршлага                                                                    | Сурч болох зүйл                                          |
|------------|------------------|------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|
| Их Британи | BBC <sup>1</sup> | Хараат бус байдлыг хангахуйц санхүүжилтийн загвар (телевизийн ашиглалтын хураамж). | Санхүүгийн хараат бус байдлыг хангах механизм бүрдүүлэх. |
|            |                  | Контентын төрөлжилт (боловсрол, соёл, олон нийт, хүүхдийн хөтөлбөр).               | Контентын чанарын стандартуудыг тогтоох.                 |
|            |                  | Цахим контент                                                                      | Хөтөлбөрийг зөвхөн телевиз, радиогоор хүргэхээс бусад    |

<sup>1</sup> Харьцуулсан судалгааны хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.



|          |                  |                                                                                                          |                                                                        |
|----------|------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|
|          |                  |                                                                                                          | цахим платформуудыг өргөнөөр үйл ажиллагаандаа нэвтрүүлэх              |
| Япон     | NHK <sup>2</sup> | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дохионы хэлний орчуулга, хадмал тайлбар бүхий контент үйлдвэрлэл. | Тусгай хэрэгцээтэй үзэгчдэд зориулсан хүртээмжийн үйлчилгээ хөгжүүлэх. |
|          |                  | Олон нийтийн боловсролын өргөн хүрээтэй контент (шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд).                       | Боловсролын контент үйлдвэрлэлд илүү анхаарах.                         |
|          |                  | Хөтөлбөрийн чанарыг сайжруулах чиг үүрэг бүхий бүтэц                                                     | Засаглал                                                               |
| БНСУ     | KBS              | Олон нийтийн боловсролын өргөн хүрээтэй контент (шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд).                       | Боловсролын контент үйлдвэрлэлд илүү анхаарах.                         |
|          |                  | Иргэдийн оролцоотойгоор контент үйлдвэрлэх <sup>3</sup>                                                  | Үзэгчдийн санал, хэрэгцээг контентод тусгах механизмыг хөгжүүлэх.      |
| АНУ      | PBS              | Иргэдийн оролцоотойгоор контент үйлдвэрлэх (санал асуулга, орон нутгийн станцуудын хамтын ажиллагаа).    | Үзэгчдийн санал, хэрэгцээг контентод тусгах механизмыг хөгжүүлэх.      |
|          |                  | Бүх мужид хүрдэг орон нутгийн онцлогт нийцсэн контент.                                                   | Орон нутгийн контентыг оновчтойгоор үйлдвэрлэх бодлого хэрэгжүүлэх.    |
| Герман   | ARD <sup>4</sup> | Олон хэл дээрх боловсрол, соёлын контент үйлдвэрлэл.                                                     | Үндэстний болон олон улсын хэл дээр контент үйлдвэрлэх.                |
|          |                  | Дижитал ур чадвар, шинжлэх ухаан, эрүүл мэндийн агуулгыг өргөнөөр хүргэх.                                | Танин мэдэхүйн контентыг дэмжих.                                       |
| Австрали | ABC <sup>5</sup> | Дижитал платформ (гар утасны апп, вэб, подкаст) ашиглан хүртээмжийг нэмэгдүүлэх.                         | Дижитал платформуудыг стратегийн төвшинд ашиглах.                      |

<sup>2</sup> Мөн тэндээс

<sup>3</sup> БНСУ-ын ӨНТХ-ийн 69-р зүйлд заасны дагуу KBS нь Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу үзэгчдийн шууд боловсруулсан үзэгчдийн оролцоотой хөтөлбөрийг оруулах ёстой.

Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон ӨНТХ-ийг хэрэгжүүлэх тогтоолын 51-р зүйлд “Үзэгчдийн оролцоотой хөтөлбөр”-ийн талаар хуульчилж өгсөн.

KBS нь өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй сувгуудад сард дор хаяж 100 минутын турш үзэгчдийн боловсруулсан үзэгчдийн оролцоотой нэвтрүүлгийг хөтөлбөртөө оруулах үүрэгтэй.

KBS нь үзэгчдийн оролцоотой хөтөлбөрүүдийг гаргах цагийг тодорхойлж, түүнийг олон нийтэд зарлах ёстой.

Үзэгчдийн оролцоотой хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн дэмжлэг болон өргөн нэвтрүүлгийн эрх зэрэг шаардлагатай асуудлуудыг БНСУ-ын Харилцаа, холбооны хорооны дүрэмд зааснаар зохицуулна.

<sup>4</sup> <https://www.ard.de/>

<sup>5</sup> <https://www.abc.net.au/>





|  |                                                                   |                                                                   |
|--|-------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
|  | Залуучуудад зориулсан интерактив, орчин үеийн контент үйлдвэрлэх. | Шинэ үеийн үзэгчдэд тохирсон богино форматтай контент үйлдвэрлэх. |
|--|-------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|

Эдгээр олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын туршлага дээр үндэслэн ОНРТ-ийн хөтөлбөрийн чанар, агуулга, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн дараах зөвлөмжийг нарийвчлан судалж үзэх, туршлага судлах шаардлагатай юм. Үүнд:

**1.Контентын чанар, агуулгыг сайжруулах зохицуулалт:** Үндэсний контентыг дэмжих эрх зүйн зохицуулалт, контентын эзлэх хувийг тодорхой тусгах.

Санал: Үндэсний соёл, түүх, хэл, уламжлалыг харуулсан контентыг дэмжих уралдаан, грант олгох хөтөлбөр хэрэгжүүлэх.

Боловсрол, соёлын контентыг нэмэгдүүлэх. Боловсрол, соёлын контент үйлдвэрлэлийг санхүүгийн болон бодлогын түвшинд дэмжих заалтыг хуульд тусгах.

Санал: Боловсрол, танин мэдэхүйн контентыг хүргэж гадна улсын жишгийг сайтар судлах

**2.Хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулалт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжийг нэмэгдүүлэх: Телевизийн бүх үндсэн нэвтрүүлэгт дохионы хэлний орчуулга, хадмал тайлбар заавал оруулах шаардлагын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Санал: Технологийн дэвшлийг ашиглан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан аудио тайлбар, дохионы хэлний орчуулгыг хөгжүүлэх.

**3.Орон нутгийн хүртээмжийг сайжруулах.** Орон нутгийн радио, телевизийн нэвтрүүлгийн дэд бүтэц, контент үйлдвэрлэлийг дэмжих. Нийт нутаг дэвсгэрт радио, телевизийн үйлчилгээний хүртээмжийг тэгш хангах технологийн шинэчлэлд хөрөнгө оруулалт хийх.

**4.Технологийн дэвшлийг ашиглах зохицуулалт:** Дижитал платформуудыг ашиглах. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийг дижитал платформоор дамжуулахыг дэмжих эрх зүйн зохицуулалтыг тусгах. Дижитал шилжилтийн санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт байдлаар тодорхойлох (төрийн дэмжлэг, олон улсын төсөл, донорын санхүүжилт). Дижитал нэвтрүүлгийн контент үйлдвэрлэх сургалт, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Санал: Гар утасны аппликейшн, подкаст, вэб платформ зэрэг сувгуудаар контентыг хүргэх.

**5.Хараат бус байдлыг хангах зохицуулалт:** Төлбөрийн хураамж, төрийн бус санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой байлгах механизм бий болгох. Телевизийн хураамжийг иргэдийн оролцоотой хэлэлцүүлж, тогтоох.

**6.Олон нийтийн оролцоог дэмжих зохицуулалт:** Үзэгчдийн санал бодлыг тусгаж, олон нийтийн санал, хүсэлтийг контент үйлдвэрлэлд тусгах эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Олон нийтийн платформ ашиглан үзэгчдийн санал бодлыг хүлээн авах, дүн шинжилгээ хийх тогтолцоо бий болгох.



**Дөрөв. Олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлсийг оновчтой тогтоох санал, зөвлөмжийн хүрээнд**

Засгийн газрын 2000 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам”-ыг үндэслэн Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын /хуучнаар/ даргын 2001 оны 403 дугаар тушаалаар Улаанбаатар хотод айл өрх 1,100, албан байгууллага 1,650, аймгийн төвд айл өрх 850, албан байгууллага 1200, сум, багийн төвд айл өрх 600, албан байгууллага 600 төгрөг байхаар телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг тогтоосон нь өнөөг хүртэл мөрдөгдөж байна.

Үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн үеийн 1 ам.долларын ханштай дүйцүүлэн баталсан байдаг бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 1 ам.доллар ойролцоогоор 3,400 төгрөгтэй тэнцсэн.<sup>6</sup> Мөн энэ хугацаанаас хойш өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ тухайн үеийнхээ хэд дахин өссөн байна. Олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлсний хэмжээг бусад өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсний хэмжээтэй харьцуулахад бага байна. *Тодруулбал*, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасны дагуу өргөн нэвтрүүлгийн телевизүүд контентоо нийлүүлсний хөлсийг Монголын Телевизүүдийн холбоо айл өрх бүрийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид төлсөн үйлчилгээний хөлснөөс сар бүр 2,500 төгрөгийг төвлөрүүлэн авч, цааш өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд хуваарилж байна.

Иймд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18.2-т заасны дагуу Засгийн газар олон нийтийн радио, телевизийн үйлчилгээний хөлсийг холбогдох тооцоо, судалгааны үндсэн дээр 2001 онд тогтоосон хэмжээг нэмэгдүүлэн тогтоох нь зүйтэй. Цаашид олон нийтийн радио, телевиз орлогоо аль болох үйлчилгээний хөлснөөс бүрдүүлж, арилжааны зар сурталчилгааны орлого болон улсын төсвөөс хамаарал багатай байх нь хараат бус бусаар нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулахад нь ач холбогдолтой.

<sup>6</sup> Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024.04.18-ны өдрийн 01/823 тоот албан бичигт дурдсанаар.



## НЭГ. ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ, ХАРААТ БУС БАЙДАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

|                                    |                                                                                                                                                |
|------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Үнэлэх хэсэг</b>                | <p><b>20 дугаар зүйл.</b>Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага</p> <p><b>24 дүгээр зүйл.</b>Үндэсний зөвлөлийн бүрэн эрх</p> |
| <b>Томьёолсон шалгуур үзүүлэлт</b> | 1.Хараат бус, бие даасан байдлыг хуулиар зохицуулж чадсан эсэх?                                                                                |

### Үнэлгээ:

*Хараат бус, бие даасан байдлыг хуулиар зохицуулж чадсан эсэх?*

Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз нь олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Эрх зүйн байдлын хувьд ОНРТ нь үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримталж, хамтын удирдлагын үндсэн дээр чиг үүргээ хэрэгжүүлэгч бие даасан байгууллага<sup>7</sup> юм.

Бие даасан байгууллага болохын хувьд зохицуулалт хийх болон хяналт тавих чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх замаар<sup>8</sup> ардчилсан засаглалын чанарыг сайжруулж шударга, зарчимч байдлыг хангах, үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх зорилготой.<sup>9</sup> Өөрөөр хэлбэл, *улс төрийн хувьд төвийг сахисан, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрөөс хараат бус, шударга ёсыг эрхэмлэж, ардчилсан засаглалын чанар, тогтвортой байдлыг хангах зорилго бүхий нийтийн эрх зүйн этгээд*<sup>10</sup> гэж ойлгодог. Улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх болоод институцийн хувьд хараат бус байх нь ардчилсан тогтолцоонд хүлээх үүргээ гүйцэтгэх гол нөхцөл болдог.

Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэнгийн тайлбарласнаар бие даасан байгууллага нь дараах үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг<sup>11</sup>:

- Төвийг сахин шударга ёсыг хамгаалагч – Төрийн үйл ажиллагааг нам, улс төрийн нөлөө, улс төрийн системийн авлигаас тусгаарлаж хамгаалах,

<sup>7</sup> Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2.хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;

<sup>8</sup> Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэнгээс “бие даасан зохицуулах болон хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагууд” (independent regulatory and oversight organization) гэж нэрлэж байна.

<sup>9</sup> О.Мөнхсайхан, *Ерөнхийлөгч: Эрх зүйн байдал, бүрэн эрх* (УБ., 2022), 145 дахь тал.

<sup>10</sup> Eliot Bulmer. *Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions*, international IDEA Constitution-Building Primer 19 (2019), 6 дахь тал.

<sup>11</sup> Б.Төрболд, *Бие даасан агентлагийн томилгооны эрх зүйн зохицуулалт (Сонгуулийн байгууллагын жишээ дээр)*. Магистрын ажил. (УБ., 2023), 6 дахь тал.



процедурын шударга ёсонд нийцэх байдлыг хянах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх;

- Бие даасан захиргааны байгууллага болохын хувьд – тодорхой салбарт зохицуулах, эсхүл захиргааны үүрэг гүйцэтгэнэ. Сайн засаглал, урт хугацааны төлөвлөлт, тогтвортой байдлыг хангах, техникийн чадавх бүрдүүлэх гэх мэт шаардлагын улмаас улс төрөөс хараат бусаар тухайн салбарыг бодлогоор хангаж ажиллах үүрэг бүхий байгууллага.

Ийнхүү бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, үндсэн зарчмыг баримталж зохицуулах нь зүйн хэрэг юм. Үүнд төрийн эрх мэдлийг аливаа этгээдэд төвлөрүүлэх бус, хуваарилах замаар хяналт, тэнцлийг хангах нь хэзээд баримтлах учиртай гол зарчим билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын нэгээхэн хэсэг болох уг зарчмын талаар<sup>12</sup> судлаачид нэлээд дурдсан байх бөгөөд Үндсэн хуулийн эхийг баригч *Б.Чимид* “1990 онд Ардчилсан хувьсгал хийж, улс оронд шинэ дэглэм тогтоож эхэлсэн цагаас төрийн байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлж эхлэхдээ “*эрх мэдэл хуваарилах зарчим*”-ыг баримтлахын зайлшгүйг танин мэдэж шинэ Үндсэн хуульдаа гол агуулгаар нь тусгав”<sup>13</sup> гэжээ.

Иймд бие даасан байгууллага нь олон улсын жишгээр ихэвчлэн Парламентаас байгуулагдаж, түүний өмнө ажлаа зохих журмын дагуу хариуцан тайлагнадаг бөгөөд Парламент, Засгийн газраас хараат бус байж, өөрөө бие даан шийдвэрлэх асуудлыг хуулиар зохицуулсан<sup>14</sup> байдаг.

Энэ жишгийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт УИХ дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэсний дотор: *6/“Ерөнхий сайд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах”, мөн 4-т “Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх” гэж заажээ.*<sup>15</sup>

Монгол Улсад үйлчилж буй хуулиудын хүрээнд бие даасан байгууллагыг гүйцэтгэх эрх мэдлийн шинжтэй тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газраас хараат бус, бие даасан, мэргэжлийн байгууллагууд гэж ойлгон зохих эрх зүйн орчныг бүрдүүлсэн.<sup>16</sup> *Тухайлбал*, захиргааны эрх зүйн талаас авч үзвэл

<sup>12</sup> Д.Одбаяр, *Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (онол, арга зүй, хэрэгжилт)* (УБ., 2017), 103 дахь тал.

<sup>13</sup> Б.Чимид, *Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс* (УБ., 2006), 89 дэх тал.

<sup>14</sup> *Тухайлбал*, Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийг улс орон даяар эрхлэн явуулах процесст шаардлагатай зүйлсийг сонгуулийн төв байгууллага өөрөө мэдэж шийдвэрлэдэг. Энэ талаар судалгааны ажлын хэсэгт дэлгэрүүлэн үзэх болно.

<sup>15</sup> Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж. Боть VIII, 194 дэх тал. *БНМАУ-ын АИХ-ын 1991.12.04-ний өдрийн хуралдааны протокол. Б.Чимид*. “Онцгой бүрэн эрх” гэдэг бол ач холбогдолтой үг. Энэ бол бусад байгууллага шийддэггүй асуудлыг хэнтэй ч хуваалцдаггүйг нь онцгой гэж байгаа юм. Хуваалцдагийг нь бол хуваалцах барих, харилцах нь бол мөн адил бусад бүрэн эрх гэж байгаа юм. Тийм учраас онцгой гэдэг бол хууль зүйн ач холбогдолтой үг. Өөрөөр хэлбэл цааш нь шилжүүлж болохгүй, манайхны ширүүхэн ярьдгаар үүний төлөө Их хурлаас өөр хэн ч хариуцахгүй гэсэн үг.

<sup>16</sup> Б.Хатантуул, *Монгол Улсын Их хурлаас байгуулагдах хараат бус, бие даасан байгууллагууд (агентлаг)-ын эрх зүйн зохицуулалт* (УБ., 2005), 21 дэх тал.



Захиргааны ерөнхий хуулийн<sup>17</sup> 5 дугаар зүйлийн 5.1-д захиргааны байгууллага нь (1) нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх, (2) бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг, (3) нийтийн эрх зүйн этгээд байна.<sup>18</sup> гэж тодорхойлсон байна.

Улмаар Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-т *“хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага”* гэсэнд бие даасан байгууллагууд байна. Тухайлбал, энэ шаардлагад ОНРТ нь зохицуулах чиг үүрэгтэй бие даасан байгууллагад хамаарч байна.

Бие даасан байгууллагын бүрэлдэхүүн нь УИХ-аас томилогдож, гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа байгуулагдаж, бүрэлдэхүүний, төсвийн, зохион байгуулалтын хувьд хараат бусаар ажиллана. Томилгоонд УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар зэрэг талуудын тэнцвэртэй оролцоо (*санал болгох, зөвшилцөх, томилох*)-г хангах замаар бие даасан, тэнцвэртэй, төвийг сахисан байдлыг баталгаажуулна.

Дүгнэвэл, бие даасан байгууллага нь *“Хараат бус, бие даасан байх”*-ын тулд:

1. Парламентаас буюу УИХ-ын оролцоотойгоор байгуулагдаж, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд ямар ч байгууллагын хөндлөнгийн оролцоогүй бие даан явуулж, УИХ-д тайлангаа танилцуулдаг;
2. Төсвөөс санхүүждэг боловч бусад төсвийн байгууллагаас ялгаатай нь хараат бус байдлыг нь хамгаалах тодорхой зохицуулалт үйлчилнэ;
3. Удирдлага нь ихэвчлэн 5-6 жилийн хугацаатай /УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанаас үл хамаарах байдлаар/-аар томилогддог.

ОНРТ-ийн 20, 21 дүгээр зүйлд заасны дагуу (1) Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага нь олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байна; (2) Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна; (3) Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна; (4) Үндэсний зөвлөл ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана<sup>19</sup>; (5) төсөв нь үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого болон улсын төсвийн дэмжлэгээс бүрддэг байхаар заасан.

Дээр дурдсан бие даасан байгууллагын шинжийг ОНРТ агуулж байгаа бөгөөд ОНРТ-ийн тухай хуулиар бие даасан, хараат бусаар ажиллах эрх зүйн зохицуулалтыг тусгасан гэж үзэж болохоор байна.

<sup>17</sup> Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2015.07.24-ний өдрийн №28 дугаарт нийтлэгдсэн.

<sup>18</sup> Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал нь эх газрын эрх зүйн системийн ойлголт, хандлагад тулгуурлан боловсруулагдсан бөгөөд Германы захиргааны эрх зүйн ойлголтыг чиг баримжаа болгож боловсруулагдсан болно.

Ц.Цогт, *Захиргааны хэргийн шүүх* (УБ., 2019), 135 дахь тал.

<sup>19</sup> Энэ талаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.11 дэх заалтад Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр УИХ тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэхээр хуульчилсан байна.



## ХОЁР. ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Үнэлэх хэсэг</b></p>                | <p>21.1.Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна.</p> <p>21.2.Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.</p> <p>21.5.Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан шалгуурыг удирдлага болгон дор дурдсан байгууллага, албан тушаалтан Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ:</p> <p>21.5.1.Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн;</p> <p>21.5.2.Монгол Улсын Их Хурал 7 хүн;</p> <p>21.5.3.Монгол Улсын Засгийн газар 4 хүн.</p> <p>21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p><b>26 дугаар зүйл.</b>Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах</p> <p><b>27 дугаар зүйл.</b>Үндэсний зөвлөлийн дарга, гишүүний ажиллах баталгаа</p> |
| <p><b>Томьёолсон шалгуур үзүүлэлт</b></p> | <p>1.ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга, зөвлөлийн гишүүний томилгоо хараат бус явагдаж байна уу?</p> <p>2.Хараат бус байдлын баталгаа нь хангагдсан эсэх?</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |

### Үнэлгээ:

#### *1.ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга, зөвлөлийн гишүүний томилгоо хараат бус явагдаж байна уу?*

ОНРТ нь Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага нь олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байна. Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх **орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй** байна. Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонголт явуулна: ... Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн ... томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонголт;<sup>20</sup> Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн **хугацаа 6 жил** байна. Үндэсний зөвлөлийн даргад сонгох хүнийг Үндэсний зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууц санал хураалтаар Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Үндэсний зөвлөлийн даргын бүрэн эрхийн

<sup>20</sup> Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг болон 30.1.1 дэх заалт





хугацаа **3 жил байх** бөгөөд түүнийг **нэг удаа улируулан сонгож** болох<sup>21</sup> эрх зүйн зохицуулалттай.

ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн; Монгол Улсын Их Хурал 7 хүн; Монгол Улсын Засгийн газар 4 хүн нэр дэвшүүлэх бөгөөд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно. Үндэсний зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон Монгол Улсын иргэнийг томилно.

УИХ-ын Тамгын газраас хийсэн судалгаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн нийт 55 нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын тогтоолоор Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлсөн байна.

**Хүснэгт 1 - Үндэсний зөвлөлийн одоогийн бүрэлдэхүүний талаарх мэдээлэл 2024.12.07-ны өдрийн байдлаар**

| Д/д | Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн нэрс | Нэр дэвшсэн сарбар, чиглэл      | Нэр дэвшүүлсэн субъект   | УИХ-ын тогтоол /томилсон огноо, дугаар/ |
|-----|------------------------------------------|---------------------------------|--------------------------|-----------------------------------------|
| 1.  | Д.Өлзийбаатар                            | Шинжлэх ухаан                   | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2019.04.19 №31                          |
| 2.  | Ж.Цэсэн                                  | Утга зохиол                     |                          | 2021.01.01 №43                          |
| 3.  | Д.Өлзийбаатар                            | Шинжлэх ухаан, Түүх             |                          | 2019.04.19 №31                          |
| 4.  | Н.Онон                                   | Соёл Урлаг                      |                          | 2022.01.14 №02                          |
| 5.  | Н.Нанзаддорж                             | Шашин, Түүх уламжлал, Ёс заншил | Монгол Улсын Их хурал    | 2024.01.17 №17                          |
| 6.  | С.Алтанцэцэг                             | Хөдөлмөр Нийгмийн хамгаалал     |                          | 2019.04.19 №31                          |
| 7.  | В.Бат-эрдэнэ                             | Биеийн тамир, Спорт             |                          | 2019.04.19 №31                          |
| 8.  | Д.Батсүх                                 | Эрх зүй                         |                          | 2019.04.19 №31                          |
| 9.  | Б.Ганболд                                | Гадаад харилцаа                 |                          | 2019.04.19 №31                          |
| 10. | Ж.Золзаяа                                | Сэтгүүл зүй                     |                          | 2023.05.04 №36                          |

<sup>21</sup> ОНРТ-ийн тухай хуулийн 21, 23 дугаар зүйл.



|     |                  |                  |                            |                |
|-----|------------------|------------------|----------------------------|----------------|
| 11. | Д.Оюун-Эрдэнэ    | Эрх зүй          |                            | 2021.01.01 №43 |
| 12. | Н.Монсор /дарга/ | Эдийн засаг      | Монгол Улсын Засгийн газар | 2023.05.04 №36 |
| 13. | Д.Цоодол         | Техник Технологи |                            | 2021.01.01 №43 |
| 14. | Н.Жанцан         | Бизнес           |                            | 2019.04.19 №31 |
| 15. | М.Уянга          | Менежмент        |                            | 2021.01.01 №43 |

Харин бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд УИХ дахь олонх болон түүний байгуулсан Засгийн газар давамгай оролцоотой бол бие даасан байдал нь алдагдаж тал засаж ажиллах, улмаар парламентын сонгуульд ялсан нам, эвсэлд хяналтгүйгээр эрх мэдэл төвлөрч, төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцэл алдагдах, цаашлаад ардчилсан үндсэн хуульт байгуулал үгүй болох эрсдэл үүснэ гэж үздэг.<sup>22</sup> Венецийн комиссоос бие даасан байгууллагуудыг бүрдүүлэхэд **“улс төржилтийг сааруулах”** зарчим дагах нь зүйтэйг анхааруулсан байдаг. Иймээс, сонгон шалгаруулах, санал болгох, томилох процедур нь боломжит хэмжээнд хоорондын зөвшилцөлд тулгуурлавал зохино. Парламентын олонхын давамгайллыг бууруулах эсхүл эрх баригч нам, эвсэлд харьяалагддаг хүнийг албан тушаалд томилох явдлыг хязгаарлах механизмыг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзсэн байдаг.<sup>23</sup>

Бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд тэнцвэрийг хангах янз бүрийн арга хэлбэр байна. *Тухайлбал:*

- (1) Парламент дийлэнх олонхын саналаар томилох;
- (2) Олон цөөнхийн хувь тэнцүүлж томилох эсхүл тус тусад нь квот өгч томилох;
- (3) Мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага зэрэг бие даасан этгээдээс санал болгох гэсэн гурван аргаар бүрдүүлэх боломжтой гэж Венецийн комисс үздэг.

Харин Ардчилал болон сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн дараах аргаар бие даасан байгууллыг бүрдүүлэх боломжтой гэж зөвлөсөн байна:

- (1) Олонх болон цөөнх хамтран томилох;
- (2) Нэр дэвшүүлэх эсхүл томилох бүрэн эрхийг парламентад суудалтай болон бусад намд хувь тэнцүүлэн олгох;
- (3) Парламент дийлэнх олонхын саналаар томилох;
- (4) Нэг институт санал болгож өөр нэгэн институт томилох;
- (5) Томилгоо хийх үүргийг олон талын төлөөлөлтэй тусгай комисст хариуцуулах;
- (6) Бие даасан нэг байгууллага нь нөгөө бие даасан байгууллагаа томилох;
- (7) Шүүх эрх мэдлийн байгууллагаас томилох<sup>24</sup> гэж тодорхойлсон байдаг.

<sup>22</sup> О.Мөнхсайхан, *Ерөнхийлөгч: Эрх зүйн байдал, бүрэн эрх* (Улаанбаатар: 2022), 155 дахь тал.

<sup>23</sup> Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition in A Democracy: A checklist,” Adopted by the Venice Commission at its 119<sup>th</sup> plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion № 845/2016, CDL-AD (2019)015,

<sup>24</sup> Eliot Bulmer. Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions, international IDEA Constitution-Building Primer 19 (2019), 24-29



Дээрхээс үзвэл, Бие даасан, хараат бус байгууллагыг бүрдүүлэхэд олон талын төлөөллийг оролцуулах, улс төрөөс хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарах ёстой нь харагдаж байна.

Манай Улсын хувьд ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүдийг Мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газарт санал болгохоор хуульчилж, Үндэсний зөвлөлийн даргыг сонгохдоо гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууц санал хураалтаар Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгож байна.

### **Хараат бус байх**

Энэ бол МҮОНРТ-ийн хамгийн сул хэсэг. Байгуулагдсанаасаа хойш төрөөс үргэлж хараат байж, улс төрийн нөлөөнд автаж ирсэн. 2012 оноос АН төрийн эрхийг авч, УИХ дарга З.Энхболд ҮЗ-д өөрийн 7 хүнийг оруулж, ОНРТ-д ногддог улсын төсвийн дэмжлэгийг нь хоёр дахин хасаж, 2006 оны 8-р сараас ажиллаж байсан Ерөнхий захирал М.Наранбаатарыг чөлөөлөв. 2015 оны 1-р сард түүний оронд АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга байсан Ц.Оюундарийг томилов. 2016 оны 6-р сард төрийн эрх МАН-д шилжив. ОНРТ-ийн төсвийг нь хасахаар сүрдүүлж, олон шалгалт оруулан түүнийг халав. 2017 оны эхээр МАН-ын Бага Хурлын гишүүн байсан Л.Нинжжамцыг оронд нь томилов. Засгийн газар анх удаа 2017 онд 5.2, 2018 онд 3.9 тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт хийж телевиз радиог тоон горимд шилжүүлэх, барилгын засвар хийх боломж өгөв. Төдөлгүй МАН дотроо хагарч Засгийн газраа солив. 2020 онд 9 тэрбум төгрөгийн улсын төсвийн дэмжлэгээс 8-р сарын тодотголоор 5.2 тэрбумыг нь танав. Цар тахлын шалтгаан байгаа ч, сайд дарга нараас хэн ч эсэргүүцсэнгүй. Ийнхүү өмнөх Засгийн томилсон удирдлагыг солих, өөрийн хүнээ томилох зорилготой үйл явдал өрнөж байгаа юм.

Эх сурвалж: Хадны завсарт хавчуулагдсан олон нийтийн радио телевиз <https://jargaldefacto.com/?p=11655>

Гэвч ОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ “түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газарт тус тус санал болгох”-оор заасан.

Дээр дурдсан мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд хэрхэн нэр дэвшигчийг санал болгож байгаа процесс, хэдээс дээш төрийн бус байгууллагууд нэгдэж нэр дэвшигчийг тодруулах асуудал ОНРТtX-иар зохицуулагдаагүй, тодорхой бус байна. Үндэсний зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлсэн, томилж байгаа талаарх УИХ-ын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс харахад санал болгож буй субъект нь “төрийн бус байгууллагаас санал болгосон” гэж л танилцуулгад дурдаж байгаа болохоос биш



ямар ямар төрийн бус байгууллагууд хэзээ, хэрхэн яаж санал болгож буй процесс байхгүй байна.

Томилгооны хувьд олон улсын жишигт нийцсэн байгаа мэт боловч анхан шатны нэр дэвшүүлэх ажиллагааны процесс хуульчлагдаж чадаагүй нь ОНРТ "...үйл ажиллагаандаа хараат бус байх, ... ил тод байдлыг эрхэмлэх, нийт үндэсний эрх ашгийг дээдлэх зарчим баримтлах" гэж заасантай зөрчилдөхөд хүргэж байна. Иймд ОНРТ-д Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газарт томилуулахаар санал болгож байгаа Үндэсний зөвлөлийн гишүүнийг анхан шатнаас нэр дэвшүүлж байгаа төрийн бус байгууллагуудын оролцооны асуудлыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байна.

Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2021-2023 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланд<sup>25</sup> Засаглалд оролцож буй субъектүүдийн ажлын уялдаа хангалтгүй, хамтарч ажиллах соёл тогтоогүй, манлайллын оновчтой хэв маягийг хэрэгжүүлээгүйгээс байгууллагын бүтээмж, үр дүнг дэмжсэн нэгдсэн удирдлага ханган ажиллах боломж алдагджээ. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл нь 2021-2023 оны хооронд хэлэлцвэл зохих зарим асуудлыг цаг тухайд нь шийдвэрлээгүйгээс байгууллагын санхүү, төсөв, хүний нөөцийн удирдлагын хүрээнд өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг доголдуулах эрсдэл үүсгэж, зарим тогтоол нь эрх зүйн маргаан дагуулж, засаглалын хувьд тогтворгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн зарим гишүүдийг холбогдох хуульд заасан мэргэжлийн шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулж томилогүйгээс Үндэсний зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чадахгүй байна.

## ***2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, хараат бус байдлын баталгаа нь хангагдсан эсэх?***

ОНРТ-ийн 26 дугаар зүйлд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах эрх зүйн зохицуулалтыг тусгасан бөгөөд мөн зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг дараах 5 үндэслэлээр эгүүлэн татахаар заасан. Үүнд:

- Эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлж өгөхийг хүссэн өргөдлийг Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн гаргасан;
- гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
- энэ хуулийн 21.3-т заасныг зөрчсөн нь сонгогдсоных нь дараа илэрсэн;
- энэ хуулийн 21.3-т заасан ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;
- Үндэсний зөвлөлийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй.

Дээрх үндэслэлүүдийн дийлэнх нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай холбоогүй буюу зөвхөн тухайн гишүүнд тавигдах нөхцөл, шаардлагатай холбоотой эгүүлэн татах үндэслэлүүд бөгөөд харин Үндэсний зөвлөлийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй бол Хяналтын зөвлөлөөс уг гишүүнийг сонгосон байгууллагад мэдэгдэж, сонгосон байгууллага тухайн гишүүнийг эгүүлэн

<sup>25</sup> Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2021-2023 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг танилцууллаа <https://audit.mn/?p=25137>



татах эсэхийг шийдвэрлэхээр зохицуулсан нь Үндэсний зөвлөлийн дарга, гишүүний үйл ажиллагаатай холбоотой хариуцлага тооцох зохицуулалт юм.

ОНРТХ-ийн 27 дугаар зүйлд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүний ажиллах баталгааг хуульчилсан бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг энэ хуулийн 26.1-д зааснаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татах эрхгүй гэж заасан нь Үндэсний зөвлөлийн хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах баталгаа болсон байна. Мөн Үндэсний зөвлөлийн гишүүдийн үндсэн ажлынх нь цалин, түүнтэй адилтгах бусад орлогын дунджийн 40 хувиас хэтрэхгүй хэмжээний урамшуулал олгох, үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь ОНРТ-ээс дэмжлэг, тусламж үзүүлэх хэлбэрээр Үндэсний зөвлөлийн гишүүний ажиллах баталгааг хангаж ирсэн байна.

Үндэсний зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Үндэсний зөвлөл өөрөө тогтоох эрхтэй бөгөөд Үндэсний зөвлөлийн 2020 оны 05 дугаар тогтоолоор урамшууллыг 500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,200.0 мянган төгрөгөөр тогтоосон. Гэвч тухайн урамшууллыг олгохдоо тодорхой шалгуур, шаардлага тавьдаггүй нь Үндэсний зөвлөлийн гишүүний үйл ажиллагааг идэвхжүүлэх, үр дүнтэй ажиллах хөшүүрэг болж байгаа эсэх нь тодорхойгүй байна.<sup>26</sup>

#### **Хуралдааны тэмдэглэлээс<sup>27</sup>**

Олон Нийтийн Радио Телевизийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангалтгүй байна. Үнэхээр цалин хөлс 700 мянгаас 1.1 сая төгрөгийн л цалин авч байна. Ийм цалинтай ажиллаж байгаа нөхцөлд ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаа ярихад бол хүндрэлтэй.

Хэдийгээр урамшууллаас өөрөөр санхүүгийн хувьд бодит дэмжлэгийн талаар зохицуулалт хуульд байхгүй ч Үндэсний зөвлөлийн гишүүдэд олгож буй урамшууллын хэмжээ нь ОНРТ-ийн ажилчдын дундаж цалингаас өндөр байгаа нь хир оновчтой эсэхийг мэргэжлийн байгууллага анхаарах шаардлагатай байна. Цаашид Үндэсний зөвлөлийн гишүүдэд олгох урамшуулал, бусад баталгааг тухайн гишүүний үйл ажиллагааны үр дүн, хариуцлагатай уялдуулах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үр дүнтэй хяналт, хариуцлагын тогтолцоо бүрдэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Үндэсний зөвлөлд хяналт тавих эрх зүйн зохицуулалтын хүрээнд өнгөрсөн хугацаанд Үндэсний зөвлөлийн нэг гишүүнийг хуульд заасан үндэслэлээр эгүүлэн татсан байна.<sup>28</sup>

<sup>26</sup> УИХ-ын Тамгын газрын судалгааны тайлангаас

Өнгөрсөн хугацаанд Үндэсний зөвлөлийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ нийт албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаар санал солилцож байгаагүй, мөн хуралдаанаа тасалсан ч ОНРТ-ийн ажилчдын дундаж цалингаас өндөр урамшуулал авч байгаа нь шударга бус байна. (ОНРТ-ийн ажилчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс ....)

<sup>27</sup> ОНРТ-ийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн үр дүнг танилцуулах Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022.04.20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс.

<sup>28</sup> Улсын Их Хурлын 2019 оны 31 дугаар тогтоолоор Содномдоржийн Санасэр нь Үндэсний зөвлөлийн хуралд 6 сараас дээш хугацаанд биечлэн оролцоогүй тул Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй гэжээ. <https://legalinfo.mn/mn/claw/14316/1614683704082920> (сүүлд 2024.12.10-ны өдөр хандсан)



Харин Үндэсний зөвлөлд хяналт тавьж ажиллах Хяналтын зөвлөлийн ажиллах нөхцөл, бүрэн эрхийг ОНРТТХийн 28, 29 дүгээр зүйлд зохицуулсан бөгөөд хяналтын зөвлөл нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Үндэсний зөвлөлийн 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-аар зохицуулж байна. Энэхүү журмын дагуу Хяналтын зөвлөлийн нэг гишүүнийг Үндэсний зөвлөлийн гишүүд дотроос, хоёр гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, нийт гишүүдийг Үндэсний зөвлөлийн нууц санал хураалтаар сонгож, томилж байна.

Хяналтын зөвлөл нь “хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг эгүүлэн татах тухай зөвлөмж гаргах эрхтэй” байхаар хуульчилсан. Хяналтын зөвлөлөөс энэ талаарх зөвлөмж гаргасан тохиолдол байхгүй байна. Учир нь томилж байгаа этгээдээ томилогдож байгаа субъект нь хянах нь зүйлд нийцэхгүй бөгөөд энэхүү эрх зүйн зохицуулалт нь практик дээр хэрэгжих боломжгүй нь харагдаж байна. Иймд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах, тэднийг хариуцлагатай байлгах үүднээс хяналтын зөвлөлийг Үндэсний зөвлөлөөс хараат бусаар томилогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, “Үндэсний зөвлөлийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй.” гэсний “6 сараас” гэснийг “3 сараас” гэж хугацааг богино болгох шаардлагатай. Ингэснээр Үндэсний зөвлөлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.






## ГУРАВ. ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН САНХҮҮЖИЛТ

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|-------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Үнэлэх хэсэг</b></p>                | <p>17 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт</p> <p>17.1.Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>17.1.1.радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс;</p> <p>17.1.2.зар сурталчилгаанаас олсон орлого;</p> <p>/Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн аваагүй/</p> <p>17.1.3.тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого;</p> <p>17.1.4.Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнээс өгсөн хандив, тусламж;</p> <p>17.1.5.улсын төсвийн дэмжлэг;</p> <p>17.1.6.хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.</p> |
| <p><b>Томьёолсон шалгуур үзүүлэлт</b></p> | <p>Олон нийтийн радио, телевизийн санхүүжилтийн бүтэц зохистой байгаа эсэх, үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох шаардлагатай эсэх? Зар сурталчилгааны олсон орлогоос санхүүжихээр заасан нь хуулийн зорилгод нийцэж байгаа эсэх?</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |

### Үнэлгээ:

*Олон нийтийн радио, телевизийн санхүүжилтийн бүтэц зохистой байгаа эсэх, үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох шаардлагатай эсэх? Зар сурталчилгааны олсон орлогоос санхүүжихээр заасан нь хуулийн зорилгод нийцэж байгаа эсэх?*


**Зураг 1. ОНРТ-ийн 2007-2023 оны нийт орлого /тэрбум.төг/**






Дээрх санхүүжилтийн эх үүсвэрүүдээс бүрдсэн ОНРТ-ийн сүүлийн 17 жилийн байдлаарх орлогыг авч үзвэл 2010 онд хамгийн бага орлоготой буюу 7.0 тэрбум төгрөг, 2018 онд хамгийн их орлоготой буюу 20.09 тэрбум төгрөг байна. Мөн сүүлийн 17 жилийн дундаж орлогыг тооцвол 13.96 тэрбум төгрөг байна.

**Зураг 2. ОНРТ-ийн санхүүжилтийн эх үүсвэрийн ангиллын 2007-2023 оны нийт орлого дахь эзлэх дүн /тэрбум.төг/**



ОНРТ-ийн нийт орлогыг эх үүсвэрээр ангилан хувилж үзвэл сүүлийн 17 жилийн байдлаар нийт орлогын 21 орчим хувийг үйл ажиллагааны орлого, 25 орчим хувийг хураамжийн орлого, 42 орчим хувийг улсын төсвийн дэмжлэг, 10 орчим хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалт бүрдүүлсэн байна.

**Зураг 3. Үйлчилгээний хөлсөөр төвлөрүүлсэн орлогын нийт орлогод эзэлж буй хувь**





Засгийн газрын 2000 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам”-ыг<sup>29</sup> үндэслэн Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын /хуучнаар/ даргын 2001 оны 403 дугаар тушаалаар Улаанбаатар хотод айл өрх 1,100, албан байгууллага 1,650, аймгийн төвд айл өрх 850, албан байгууллага 1200, сум, багийн төвд айл өрх 600, албан байгууллага 600 төгрөг байхаар телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг тогтоосон нь өнөөг хүртэл мөрдөгдөж байна.

ОНРТ-ийн 18.2-т “Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газраар тогтооно” гэж заасан боловч хуулийн энэ зохицуулалтын дагуу Засгийн газар ОНРТ-ийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоогоогүй байна.

ОНРТ-ийн Үндэсний зөвлөлөөс үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох буюу одоо авч байгаа үйлчилгээний хөлсний хэмжээг нэмэгдүүлэх саналыг 2012 оноос хойш хэд хэдэн удаа Засгийн газарт хүргүүлж байсан боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна. 2001 онд үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн үеийн 1 ам.долларын ханштай дүйцүүлэн баталсан байдаг бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 1 ам.доллар ойролцоогоор 3,400 төгрөгтэй тэнцсэн.<sup>30</sup>


ОНРТ-ийн үйлчилгээний хөлсний хэмжээг бусад өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсний хэмжээтэй харьцуулахад бага байна. *Тодруулбал*, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ дараах төрөлтэй байна.” гээд 6.1.2-т “олон суваг дамжуулах үйлчилгээ” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3-д “өргөн нэвтрүүлгийн телевизүүд нь энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэж заасны дагуу одоогийн байдлаар өргөн нэвтрүүлгийн телевизүүд контентоо нийлүүлсний хөлсийг Монголын Телевизүүдийн холбоо олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс төвлөрүүлэн авахаар хуульчилсны дагуу айл өрхийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид төлсөн үйлчилгээний хөлснөөс сар бүр 2,500 төгрөгийг төвлөрүүлэн авч, өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд хуваарилж байна.

<sup>29</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=2454>

<sup>30</sup> Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024.04.18-ны өдрийн 01/823 тоот албан бичигт дурдсанаар.



**Зураг 4. Үйл ажиллагааны орлогын нийт орлогод эзэлж буй хувь**



ОНРТ-ийн үйл ажиллагааны орлого нь зар сурталчилгааны орлого, төлбөртэй нэвтрүүлгийн орлого, түрээсийн орлого болон бусад орлогоос бүрдэж байна.

Өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаанаас олох нийт орлогын ихэнх хувийг захиалгат нэвтрүүлгийн орлого эзэлж байсан бөгөөд хамгийн сүүлд Үндэсний зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар тогтоолоор “Үндэсний телевизийн ажил үйлчилгээний тарифыг баталсан байна.

Зар сурталчилгааны орлогыг Ерөнхий захирлын 2021 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “МҮОНРТ-ээр нэвтрүүлэх зар сурталчилгаа болон нэвтрүүлгийн ивээн тэтгэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу төвлөрүүлж байна<sup>31</sup>. ОНРТ-ийн үйл ажиллагааны орлогод эзлэх зар сурталчилгааны орлогын хувь хэмжээ ямар түвшинд байсан болон шинэ сувгууд үйл ажиллагаа явуулснаар зар сурталчилгааны орлогын хувь хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн талаар тодруулахаар ОНРТ-ийн 2007-2021 оны төсвийн орлого, зарлагын мэдээтэй танилцсан боловч төсвийн орлогын ангилал хэсэгт “зар сурталчилгааны орлого” гэсэн ангилал байхгүй байна.<sup>32</sup>

#### **Зар сурталчилгааны орлогын эрх зүйн зохицуулалтын талаар:**

Улсын Их Хурлаас 2005 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Олон нийтийн, радио телевизийн тухай хуулийг баталсны дараа хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 13 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, 21 дүгээр зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьж байсан байна.

<sup>31</sup> Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. (УБ., 2022)

<sup>32</sup> Мөн тэнд.



Хуулийн 17 дугаар зүйлд олон нийтийн радио телевизийн санхүүжилтийн нэг эх үүсвэр нь “зар сурталчилгаанаас олсон орлого” байхаар хуульчлан зааж, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт олон нийтийн радио телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон нь уг хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт олон нийтийн радио телевизийн “ашгийн төлөө бус хуулийн этгээд” хэмээн тодорхойлсонтой зөрчилдөж, Монголын ард түмэнд үйлчлэх эрхэм зорилготой нь харшилна гэж үзэж байна. Дээрх заалт нь мэдээллийн зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг боомилсон, бусад хэвшлийн телевизүүдийн хэвийн үйл ажиллагаа явуулах, хөгжих эдийн бололцоо нөхцлийг хааж, улмаар иргэдийн олон ургальч мэдээлэл авах, сонголт хийх эрхийг хөсөрдүүлж болзошгүй гэсэн мэргэжлийн хүмүүсийн санаа бодлыг ч анхаарч үзэх нь зүйтэй юм.<sup>33</sup>

**Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандиас “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль”-д хэсэгчлэн тавьсан хоригоос.**

Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцээд 13 дугаар зүйлд заасан хоригийг хүлээн авч тус зүйлийг өөрчлөн найруулсан бол 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтад тавьсан хоригийг хүлээж аваагүй байна.

**Хүснэгт 2 - Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч өөрчлөн найруулсан хувилбар**

| Хуулийн уг эхийн хувилбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч өөрчлөн найруулсан хувилбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>13 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаа</b></p> <p>13.1.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна</p> <p>13.2.Олон нийтийн радио, телевизээр далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.</p> <p>13.3.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд дараахь тусгай шаардлагыг тавина:</p> <p>13.3.1.хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэх;</p> <p>13.3.2.улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх, мөн ийм мэдээллийн нэвтрүүлэгч зар</p> | <p><b>13 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаа</b></p> <p>13.1.Олон нийтийн радио, телевизээр <b>арилжааны болон</b> далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.</p> <p>13.2.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд дараахь тусгай шаардлагыг тавина:</p> <p>13.2.1.хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэх;</p> <p>13.2.2.улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх, мөн ийм мэдээллийн нэвтрүүлэгч зар сурталчилгаа бэлтгэх, бүтээх, дамжуулахад оролцохгүй байх;</p> |

<sup>33</sup> Улсын Их Хурлын Тамгын газар. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хувийн хэрэг.



|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>сурталчилгаа бэлтгэх, бүтээх, дамжуулахад оролцохгүй байх;</p> <p>13.3.3.сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 10 минутад 10 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлэх;</p> <p>13.3.4.зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг дуу, авиа, дүрсээр ялгахуйц байдлаар нэвтрүүлэх;</p> <p>13.3.5. 20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх.</p> <p>13.3.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна.</p> | <p>13.2.3.сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 10 минутад 10 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлэх;</p> <p>13.2.4.зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг дуу, авиа, дүрсээр ялгахуйц байдлаар нэвтрүүлэх;</p> <p>13.2.5. 20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх.</p> <p>13.3.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна.</p> <p>13.4.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна.</p> |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Дээрхээс үзэхэд, Улсын Их Хурал ОНРТТХ-ийн 13 зүйлд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч, тус зүйлийг өөрчлөн найруулсан боловч гол өөрчлөлт нь олон нийтийн радио, телевиз нь “далд зар сурталчилгаа”-аас гадна “арилжааны зар сурталчилгаа” явуулахыг хориглосон өөрчлөлт байна.

ОНРТТХ-ийн 13.1-д “Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно” гэж, 13.3-т “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна” гэж заасан ба тус хуулийн 13.2-т зар сурталчилгаатай холбоотой дараах шаардлагыг тусгасан:

*“13.2.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд дараахь тусгай шаардлагыг тавина:*

*13.2.1.хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэх;*

*13.2.2.улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх, мөн ийм мэдээллийн нэвтрүүлэгч зар сурталчилгаа бэлтгэх, бүтээх, дамжуулахад оролцохгүй байх;*

*13.2.3.сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 10 минутад 10 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлэх;*

*13.2.4.зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг дуу, авиа, дүрсээр ялгахуйц байдлаар нэвтрүүлэх;*

*13.2.5. 20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх.”*





Зар сурталчилгааны тухай хуулийн 3.1.1-д "зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг" ойлгоно гэж заасан.

Зар сурталчилгааны тухай хуулиар "арилжааны зар сурталчилгаа" гэсэн ойлголтыг тусгайлан тайлбарлаж, зохицуулаагүй байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-ын<sup>34</sup> 2.3-т "Арилжааны зар сурталчилгаа гэдэгт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн бараа, ажил, үйлчилгээ, үйл ажиллагааны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах, ашиг олох зорилгоор төлбөртэй, эсвэл түүнтэй дүйцэхүйц нөхцөлөөр нэвтрүүлж буй богино хэмжээний зар мэдээллийг ойлгоно" гэж заасан байна.

Зар сурталчилгааны тухай хуулийн 7.5-д "Энэ хуулийн 6.1-д заасныг<sup>35</sup> зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно" гэж заасан ба "далд зар сурталчилгаа" нь "хууль бус зар сурталчилгаа"-нд хамаарч байна.<sup>36</sup> Мөн хуулийн 15.1-д "Иргэн, хуулийн этгээдээс нийтийн болон улсын эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлс, иргэдэд хог хаягдлын талаар боловсрол олгохыг болон соёлын өвийг хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зар сурталчилгааг бүтээх, түгээх, эсхүл өөрийн хөрөнгийг энэхүү зар сурталчилгааг бүтээх, түгээхэд зориулан бусдад хариу төлбөргүйгээр шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг нийгмийн зар сурталчилгаанд хамааруулж, хууль тогтоомжид заасны дагуу хөнгөлөлт үзүүлж болно" гэж заасан. Дээр дурдсан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-ын 2.9-д "Нийгмийн зар сурталчилгаанд нийтийн болон улс орны эрх ашгийн төлөө, нийтэд ашиг тустай үйлс, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх, боловсрол олгох, дэмжих зорилгоор бүтээсэн арилжааны бус зар сурталчилгааг ойлгоно" гэж заасан байна.

**Нэгтгэн дүгнэхэд,** Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, хуулийг баталсан үеийн үзэл баримтлал, Ерөнхийлөгчийн тус хуульд хэсэгчлэн тавьсан хориг, түүний дагуу хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Зар сурталчилгааны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиудын зохицуулалтыг уялдуулан авч үзвэл олон нийтийн радио, телевиз зөвхөн "нийгмийн зар сурталчилгаа" явуулах боломжтой байх ба ийнхүү нэвтрүүлэх зар сурталчилгаанд ОНРТТХ-ийн 13.2, 13-т заасан шаардлагууд тавигдахаар байна. Өөрөөр хэлбэл, ОНРТТХ-ийн 17.1.2-т

<sup>34</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123495453851&showType=1>

<sup>35</sup> Зар сурталчилгааны тухай хууль. "6.1.Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна"

<sup>36</sup> Зар сурталчилгааны тухай хууль. 7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна"



заасан “зар сурталчилгаанаас олсон орлого” гэдгийг мөн хуулийн 13 дугаар зүйлийн зохицуулалттай уялдуулан авч үзэхэд, энэ нь “нийгмийн зар сурталчилгаанаас олсон орлого” гэж үзэхээр байна.

**Ц.Мөнхцэцэг:** Ажлын хэсэг болон олон нийтийн радио, телевизийн удирдлагаас нэг асуулт байна. ... Хоёрдугаарт нь энэ ажлын хэсгийн тайлан дээр бол бас байна. Ер нь бол хуулийн төсөл дээр 13.1 дээр ингээд Олон Нийтийн Радио Телевиз бол энэ арилжааны чанартай болон далд сурталчилгаа бүхий ийм зар сурталчилгаа хийхийг хориглож байгаа. Ер нь бол нийтийн эрх ашгийн төлөө хүний эрх, тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна уу, ардчилал, үнэт хүний эрхийн, Үндсэн хуулийн талаар зар сурталчилгаанууд явах ёстой. Гэтэл бид нар бол бүгд мэдэж байна. Манай үзэгчид бид нар бол бүгд харж байгаа. Бусад телевизүүдээс ялгарах юмгүйгээр арилжааны зар сурталчилгаа явдаг. Ер нь цаашдаа ийм байх ёстой юу? Түрүүн бас манай зарим гишүүд бол ярьж байна. Ер нь Олон Нийтийн Радио Телевизийн зар сурталчилгаа гэж байх ёстой юм уу, үгүй юу? Энэ тал дээр энэ удирдлагын болон Үндэсний зөвлөлийн гишүүд ямар байр суурьтай байгаа вэ? Мөн манай ажлын хэсгээс яг энэ зар сурталчилгааны хувьд бол ямаршуу байр суурьтай байх ёстой вэ?

Ер нь бол олон нийтийн телевиз бол улс төрийн болон бизнесийн ашиг саналаас ангид байх ёстой. Тэр утгаараа аль болохоор улсын төсвөөс хангалттай дэмжлэг өгөөд ямар нэгэн байдлаар арилжааны эрх ашиг гэдэг юм уу сэдэл бүхий нэвтрүүлэг зар сурталчилгаа явуулах ёсгүй юм байдаг. Энэ дээр байр суурь ямар байгаа вэ гэдэг ийм хоёр асуулт асуумаар байна.

**А.Бүрэнбаатар:** ... Реклам, зар сурталчилгаа гэхээр манайх 3 эх үүсвэрээс санхүүжиж байгаа. Улсын төсвийн дэмжлэг, хураамжийн орлого, үйл ажиллагааны орлого гээд. Тэгэхээр үйл ажиллагааны орлого бол үндсэндээ манай нийт төсвийн бол бага хувийг эзэлж байгаа дотроо. Тэгэхээр яах вэ зүгээр хуульд бол хэдийгээр нийгмийн шинж чанартай, далд рекламыг л явуулна гэж заасан боловч бид нар зүгээр олон жилийн юу гэдэг юм явж ирсэн энэ зарчмаараа л бол явж байна. Үнэхээр бол зүгээр өнөөдрийн нөхцөл байдалд бол бид нар энэ арилжааны сурталчилгаа явуулахгүйгээр дан нийгмийн шинж чанартай сурталчилгаа явуулна гэж үзэх юм бол оршин тогтнох бол ямар ч үндэс байхгүй байж байгаа. Төсвийн тавьж өгч байгаа, баталж байгаа энэ үйл явц маань өөрөө тогтворгүй тавигдсан төсвөөс ингээд танагдаад байдаг учраас бид нар бол бас нэлээн хүндрэлтэй байна.

**Ж.Мөнхбат:** Үндэсний зөвлөл ч яах вэ Энэ найман гишүүн наймуулаа хариулах юм уу? Дарга нь ирээгүй байна. Шүүх хуралтай гээд нэгийг нь төлөөлөөд хариулах уу? Тийм, бие даасан статустай учраас тийшээ л очно доо. Нэг, хоёрын дугаар номерын микрофон дээр л очиж ярих болчихоод байна. Товч товч хариулчих юм уу? Төлөөлөөд хоёр хүн хариулчихъя. Чилаажав, Наранбаатар хоёр. Хоёр номерын микрофон өгье.

**М.Наранбаатар:** ... Арилжааны зар сурталчилгаа энэ бол ерөөсөө эхнээсээ хэл амтай бас ингээд эрх зүйн орчин нь бас ойлгомж муутай, ийм явж ирсэн. Нийгмийн чиглэлийн зар сурталчилгаа гэж юуг ойлгох вэ? Зар сурталчилгааны хуульд үзэх юм бол хоёр заалт бий, тэр бас их ойлгомжгүй байдаг. Тухайн үедээ би Олон нийтийн радиогийн ерөнхий захирлаар ажиллаж байсны хувьд Улсын дээд шүүхийн иргэний танхимд одоо та бүхэн тодорхой болгоод өгөөч гэдэг ийм зүйл хүртэл оруулж байсан. Тухайн үедээ бол хуулийн тайлбар хийж өгөөгүй. Түрүүн Бүрэнбаатар захирал дурдлаа, зар сурталчилгаагаар



тухайн хэвлэл мэдээллийн байгууллага өөрийг бүрэн санхүүжүүлээд явах олон нийтийн болоод ийм хуультай байх юм бол төрөөс жишээ нь тусгайлан төсөв өгөөд энэ асуудлыг шийдэх, хосолсон төсвийн дэмжлэг болоод зар сурталчилгаа гэдэг ийм хэсэг байж болдог гэх мэт ингээд олон улсад бол.../минут дуусав./

**Ж.Мөнхбат:** Нэг номерын микрофон Үндэсний зөвлөлийн гишүүн Чилаажав.

**Х.Чилаажав:** ... Ийм нөхцөлд бол бид амьдрахын тулд заримдаа бол Үндэсний зөвлөл мэдсэн ч мэдээгүй юм шиг царайлаад энэ арилжааны зар сурталчилгаанууд явж байгааг тэвчин өнгөрөөж байгаа ийм тал бол байгаа шүү. Тэгэхдээ бид бол аль болохоор Үндэсний зөвлөлийн хуралдаан болон бусад баримт бичиг дээрээ бол хуулиа хэрэгжүүлж ажиллаа. Арилжааны зар сурталчилгаа явуулахгүй ээ, ингэхгүй ээ, тэгэхгүй гэдэг юмыг бол байнга Үндэсний зөвлөлийн зүгээс бол барьж ажилладаг. Хяналтын зөвлөл ч энэ дээр бас хяналтаа тавьж ажилладаг гэж ингэж ойлгож болох байх гэж бодож байна.

**Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы төрийн байгуулалтын байнгын хорооны 04 дүгээр сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны тэмдэглэлээс.**

ОНРТ-ийн телевизийн 1 дүгээр суваг буюу MNB Үндэсний телевизээр нэвтрүүлсэн арилжааны зар сурталчилгааны хугацааны талаарх статистик мэдээллээс үзэхэд 2017-2021 онуудад нийт 586 өдрийн арилжааны зар сурталчилгааны хувь хэмжээг хуульд заасан хязгаараас хэтрүүлсэн буюу тухайн өдрүүдийн эфирийн цагийн 2.1 хувиас 11.5 хүртэлх хувийг арилжааны зар сурталчилгаа эзэлж байгаа буюу жилийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл 2017 оноос бусад жилүүдэд арилжааны зар сурталчилгааны хувь нь хуульд заасан хязгаараас хэтэрсэн буюу 2.1-2.4 хувьтай байна.<sup>37</sup>

Олон нийтийн радио, телевиз нь үйлчилгээний хөлс, улсын төсөв болон арилжааны шинжтэй үйл ажиллагаанаас олсон орлогоос санхүүждэг. Энэ нь бусад хувийн хэвшлийн телевизүүдтэй харьцуулахад давуу талтай. Улсын төсвөөс дэмжлэг авдаг мөртлөө бусад хувийн хэвшлийн телевизүүдтэйгээ өрсөлдөх шинжтэй арилжааны үйл ажиллагаа явуулж орлого олохыг зөвшөөрөөд байдаг нь ойлгомжгүй. Олон нийтийн, радио телевизийн тухай хуульд арилжааны шинжтэй үйл ажиллагаа явуулах, зар сурталчилгаа явуулах асуудал дээр хориглолт, хязгаарлалтууд байдаг ч бодит байдал дээр үүнийгээ дагаж мөрдөж, баримталдаг нь эргэлзээтэй. Жишээ нь сугалааны тохирол шууд дамжуулж байгаа ч харагддаг. Энэ нь болох юм уу, хуульдаа нийцэж байгаа юу гэдэг дээр хяналт сул, байхгүй юм шиг ажиглагддаг.

**Монголын Телевизүүдийн холбооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас.**


Хэдийгээр ОНРТтХ-аар олон нийтийн радио, телевизийг “арилжааны зар сурталчилгаа” явуулахыг хориглосон ч бодит байдал дээр МҮОНРТ нь “арилжааны зар сурталчилгаа” явуулж орлого олдог, үүнийгээ ч өөрсдөө хүлээн зөвшөөрдөг байна. Нөгөөтэйгүүр, ОНРТтХ-ийн 13.3-т “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн

<sup>37</sup> Мөн тэнд.



хоёр хувиас хэтрэхгүй байна” гэж заасан нь уг хугацааны хязгаарт багтаан “арилжааны зар сурталчилгаа” явуулж болох юм шиг ойлгомжгүй зохицуулалт болсон байна. Нөгөө талаас, олон нийтийн радио, телевиз нь зөвхөн “нийгмийн зар сурталчилгаа” явуулах ёстой гэж үзвэл, уг зар сурталчилгаанд хугацааны хязгаарлалт байх шаардлагатай юу гэдэг асуудал үүснэ. Учир нь Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.19-т зааснаар “өргөн нэвтрүүлгийн телевиз” нийгмийн зар сурталчилгааг явуулах тохиолдолд мөн журмын 3.2-т заасан “нэг цаг тутамд нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа 15 (арван тав) минутаас илүүгүй байх” шаардлага хамаарахгүй байхаар заасан байдаг байна.

**Зураг 5. Улсын төсвийн дэмжлэгийн нийт орлогод эзэлж буй хувь**



Дээрхээс үзэхэд, ОНРТ-ийн тухайн жилийн төсвийн 30-50 хувь нь улсын төсвийн дэмжлэгээс шууд хамааралтай байгаа нь харагдаж байна. 2007-2019 оны хугацаа дахь улсын төсвийн дэмжлэгийн хэмжээ дунджаар нийт орлогын 50 буюу түүнээс дээш хувийг эзэлж байсан бол 2020 оноос хой хойш улсын төсвийн дэмжлэгийн дундаж хэмжээ нийт орлого дахь эзлэх хувь 50 хувь хүрээгүй байна.

**Хүснэгт 3 - Бусад улсын олон нийтийн телевизүүдийн санхүүжилтийн бүтэц**

| Улс     | Телевиз | Санхүүжилтийн бүтэц |                   |                        |
|---------|---------|---------------------|-------------------|------------------------|
|         |         | Төсвийн дэмжлэг     | Үйлчилгээний хөлс | Үйл ажиллагааны орлого |
| ИБУИНВУ | BBC     | -                   | 65%               | 35%                    |
| Япон    | NHK     | -                   | 96%               | 4%                     |
| БНСУ    | KBS     | -                   | 47%               | 53%                    |
| ХБНГУ   | DW      | 96%                 | -                 | 4%                     |
| Монгол  | МҮОНРТ  | 24%                 | 41%               | 35%                    |



Бусад улсын амжилттай, тогтвортой ажиллаж буй олон нийтийн телевизийн санхүүжилтийн бүтцийг харахад нэг бол төсвийн дэмжлэг, нэг бол үйлчилгээний хөлсөөр орлогынхоо дийлэнх хувийг бүрдүүлж байгаа нь харагдаж байна.

Энд үйл ажиллагааны орлого нь зар сурталчилгааны орлогоос өргөн агуулгатайг тэмдэглэх нь зүйтэй. Үүнд, олон нийтийн телевиз нь чанартай контент бүтээгээд түүнийг арилжааны хувийн телевизүүдэд борлуулах хувилбар ч байж болно.

*Тухайлбал*, Японы NHK нь бизнесийн борлуулалттай холбоотой зар сурталчилгаа дамжуулахыг хуулиар хориглодог боловч үйл ажиллагааны санхүүжилтийг нөхөх зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаатай холбоотой бүтээгдэхүүн, хөтөлбөр, үйлчилгээг борлуулах болон хөтөлбөрийн редакцын шаардлагаар, борлуулалтын зар сурталчилгааны зорилгогүйгээр зохиогчийн эсхүл бизнес эрхлэгчийн нэр болон бусад мэдээллийг дамжуулахыг зөвшөөрдөг. Их Британы BBC нь өөрөө бус өөрийн арилжааны үйл ажиллагааг эрхлэх компаниар дамжуулан BBC-ын нэр хүнд үнэ цэнийг алдагдуулахгүй, зах зээлийг гажуудуулж, шударга бус өрсөлдөөний давуу талыг бий болгохооргүй арилжааны үйл ажиллагааг эрхлэн орлого олох боломжтой. Одоогийн хүчин төгөлдөр Суурь гэрээний 29.3-т зааснаар BBC болон Британийн бусад нэвтрүүлгийг гадаадад нэвтрүүлж, орлого олох зорилго бүхий BBC Worldwide Limited (кино, контент бүтээдэг BBC Studio үүнд хамаарна), BBC Global News Limited, BBC Studioworks Limited зэрэг нь BBC-ын арилжааны компаниуд юм. Мөн тодорхой арилжааны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор шинэ охин компани, хамтарсан компанийн BBC-ын Удирдах зөвлөл байгуулж болох бөгөөд уг үйл ажиллагаа нь дээр дурдсан шаардлагад нийцэж байгаа эсэхэд Соёл, хэвлэл мэдээлэл, спортын төрийн нарийн бичгийн дарга хяналт тавьдаг байна.<sup>38</sup>

<sup>38</sup> Энэхүү тайлангийн харьцуулсан судалгааны хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.



## ДӨРӨВ. ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО, ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

|                             |                                                                                                                                                                                 |
|-----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үнэлэх хэсэг                | <p><b>8 дугаар зүйл.</b> Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого</p> <p><b>9 дүгээр зүйл.</b> Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрт тавигдах тусгай шаардлага</p> |
| Томьёолсон шалгуур үзүүлэлт | ОНРТ-ийн хөтөлбөрийн бодлого ОНРТтХ-иар тодорхойлсон бодлого, хөтөлбөрт тавигдах тусгай шаардлагад нийцэж буй эсэх?                                                             |

### Үнэлгээ:

*ОНРТ-ийн хөтөлбөрийн бодлого ОНРТтХ-иар тодорхойлсон бодлого, хөтөлбөрт тавигдах тусгай шаардлагад нийцэж буй эсэх?*

ОНРТ-ийн зорилго нь үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгох<sup>39</sup> бөгөөд уг зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд олон нийтэд түгээх хөтөлбөрийн төрөл, бодлого болон хөтөлбөр тавигдах шаардлага ямар хэмжээнд байх тухай харилцааг ОНРТтХ-ийн 8, 9 дүгээр зүйлээр тусгайлан зохицуулсан байна.

### 1.Хөтөлбөрийн бодлого

ОНРТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Олон нийтийн радио, телевиз улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгоно” хэмээн зохицуулж, хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараах бодлогыг баримтлахыг хуульчилсан. Үүнд:

- ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх;
- улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх;
- үндэсний соёл, урлаг, түүх, ёс заншил, уламжлалыг хүндэтгэх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, хүрээлэн байгаа орчноо хамгаалахыг дэмжих;
- энх тайвныг сахин хамгаалахыг тууштай дэмжих, улс орнуудын хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх;
- соёл, урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц уран бүтээлийн бүх хэлбэрийг дэлгэрүүлэн хөгжүүлэх;
- хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих, ялангуяа хүүхэд, залуучуудын оюуны болон бие бялдрын хөгжилд онцгой анхаарах;
- үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх гэжээ.<sup>40</sup>

<sup>39</sup> Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг

<sup>40</sup> Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг





## 2.Хөтөлбөрт тавигдах шаардлага

ОНРТ-ийн хөтөлбөрт тавигдах тусгай шаардлагын тухайд дараах нөхцөлүүдийг хуульчилсан байна. Үүнд:

- ОНРТ-ийн хөтөлбөр нь үнэн бодит мэдээлэл агуулсан, мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, нэг талыг баримтлаагүй, сэтгүүлчийн ёс зүйн зарчмыг баримталсан, шуурхай байх;
- ОНРТ-ийн тухайн өдрийн хөтөлбөрт мэдээ, мэдээллийн болон сонсогч, үзэгчдийн танин мэдэхүйн хэрэгцээг хангахад чиглэгдсэн нэвтрүүлэг зохистой харьцаагаар тусгагдсан байх;
- ОНРТ-ээр аливаа нийтлэл, нэвтрүүлгийг түгээхийн өмнө түүний агуулга, үүсэл, үнэн бодит байдлыг тухайн нийтлэл, нэвтрүүлгийг бэлтгэсэн сэтгүүлч, редакц шалгах ёстой бөгөөд тухайн мэдээ, мэдээлэл хуурамч болох нь илт мэдэгдэж байгаа, хуурамч гэдгийг мэдсэн, хуурамч гэж тооцох бодитой үндэслэл байгаа гэж үзвэл түүнийг түгээхгүй байх;
- ОНРТ-ээс хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдах;
- Хуулиар хориглоогүй боловч хүүхэд, залуучуудын бие махбодь, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлж болохуйц агуулга бүхий нэвтрүүлэг, баримтат болон уран сайхны киноны дамжуулах цагийг зохицуулах, эсхүл техникийн бусад арга хэмжээг ашиглах замаар хязгаарлалт тогтоож болно;
- ОНРТ-ийн мэдээллийн болон сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нь дохионы хэлний орчуулгатай гарах ба урсгал мэдээлэл явуулах, бичгэн мэдээллийг хараагүй иргэнд зориулан нэвтрүүлж байна.
- ОНРТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2.6-д заасан хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих, ялангуяа хүүхэд, залуучуудын оюуны болон бие бялдрын хөгжилд онцгой анхаарах чиглэлээр гарч буй нэвтрүүлэг нь залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийн тусгайлан тогтоосон цагтай байх<sup>41</sup> зэрэг болно.

ОНРТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.4, 24 дүгээр зүйлийн 24.1.5-д зааснаар ОНРТ-ийн хөтөлбөр нь дээр дурдсан бодлого, тусгайлсан шаардлагад нийцэж буй эсэхэд Үндэсний зөвлөл хяналт тавих бөгөөд хөтөлбөрийн бодлогыг хуульд нийцүүлэн тодорхойлох бүрэн эрхийг ОНРТ-ийн Ерөнхий захирал хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг ОНРТ-ийн Ерөнхий захирлын 2015 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “МҮОНРТ-ийн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах, түүнтэй холбогдох харилцааг зохицуулах багц журам”-аар зохицуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.<sup>42</sup>

ОНРТ-ээс сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгох зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах сувгуудыг эрхлэн гаргаж байна.

<sup>41</sup> Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үзнэ үү.

<sup>42</sup> УИХТГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний газар, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан (УБ., 2022), 22



| Д/д                     | Сувгийн нэр               | Үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо | Үйл ажиллагааны чиглэл                                                                                         |
|-------------------------|---------------------------|------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>ТЕЛЕВИЗИЙН СУВАГ</b> |                           |                                    |                                                                                                                |
| 1                       | MNB Үндэсний телевиз      | 1967 он                            | Үндсэн суваг буюу өргөн хүрээнд нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг.                                                   |
| 2                       | Монголын мэдээ            | 2014 он                            | Өдөрт 16-17 цагийн мэдээ бэлтгэн хүргэдэг.                                                                     |
| 3                       | MNB World                 | 2018 он                            | Англи хэл дээр нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг.                                                                    |
| 4                       | MNB Спорт                 | 2018 он                            | Үндэсний болон олон улсын спортын онцлох үйл явдал, зарим спортын тэмцээн, уралдааныг шууд дамжуулан хүргэдэг. |
| 5                       | MNB Гэр бүл               | 2020 он                            | Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг.                           |
| <b>РАДИОГИЙН СУВАГ</b>  |                           |                                    |                                                                                                                |
| 1                       | MNB Монголын радио        | 1934 он                            | Үндсэн суваг буюу өргөн хүрээнд нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг.                                                   |
| 2                       | Монголын дуу хоолой радио | 1964 он                            | Япон, Англи, Орос, Хятад гэсэн 4 хэл дээр нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг.                                         |
| 3                       | P3                        | 2008 он                            | Хүүхэд, залуучуудад чиглэсэн дуу хөгжим, мэдээ мэдээлэл, цэнгээнт шоу хөтөлбөр бэлтгэн хүргэдэг. <sup>43</sup> |

### 3. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн харьцуулалт

Монгол Улсын Их хурлаас 2019 онд баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар ОНРТ-ээс бусад радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчээс хөтөлбөр бэлтгэн хүргэхэд тавигдах ерөнхий шаардлагыг тусгайлан хуульчилсныг ОНРТтХ-тай харьцуулан судалж, цаашид ОНРТ-ийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хуульчлах шаардлагатай байж болох юм.

Судалгааны өмнөх хэсэгт дурдсанчлан ОНРТтХ-иар ОНРТ-ийн хөтөлбөрийн бодлого болон хөтөлбөрт тавигдах шаардлагыг тусгайлан хуульчилсан давуу талтай боловч Өргөн нэвтрүүлгийн тухай хуультай харьцуулж үзвэл орхигдуулсан харилцаа, нэмж тусгах шаардлагатай зохицуулалтууд байгаа болохыг харж болно.

Тухайлбал, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлд радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчээс олон нийтэд хүргэх хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлагыг хуульчилсан бөгөөд эдгээрээс дараах онцлог зохицуулалтыг түүвэрлэн судаллаа.

Хөтөлбөр тавигдах шаардлага:

- Гадаад нэвтрүүлгийг дамжуулахдаа Монгол хэлээр дуу оруулсан, эсхүл бичгэн орчуулгатай байна.

<sup>43</sup> УИХТГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний газар, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан (УБ, 2022), 23



- Өөрийн бүтээсэн болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийг дамжуулна;
- Гамшгийн болон онцгой байдал, урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журмыг дагаж мөрдөнө;
- Дамжуулж байгаа хөтөлбөр нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эрх ашигт харшлахгүй байна;<sup>44</sup>

Бүтээлийн хувь хэмжээг тусгайлан хуульчилсан:

- Үндэсний бүтээл;
- Орон нутгийн бүтээл;
- Өөрийн бүтээл;
- Хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлэг;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн хөтөлбөрт эзлэх үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг<sup>45</sup> гэх байдлаар бүтээлийн хувь хэмжээг хуульчилсан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6-д зааснаар эдгээр хөтөлбөрт тавигдах шаардлагыг нарийвчлан батлах эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд олгосон байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 сарын 29-ний өдрийн 01 дугаар тогтоолоор “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ыг баталсан. Уг журмаар хөтөлбөрийн бодлого, зарчим, түүнд тавигдах шаардлага, хяналт тавих харилцааг дэлгэрүүлэн зохицуулсан.

“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ийн 3.2-т “Өргөн нэвтрүүлгийн телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 60 хувиас доошгүй нь үндэсний бүтээл, нэвтрүүлэг байна”, 3.4-т “Телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь өөрийн бүтээл, нэвтрүүлэг байх бөгөөд өөрийн редакцын бодлогын хүрээнд тухайн телевизэд бэлтгэсэн байна” гэх зэргээр хөтөлбөрийн бүтэц, хувь хэмжээг нарийвчлан зохицуулжээ.

ОНРТ-ийн тухайд Ерөнхий захирал ОНРТТХ-иар тодорхойлсон хөтөлбөрийн бодлогын хүрээнд нэвтрүүлгийн хөтөлбөрийг тогтоох бүрэн эрхийг эдэлж байгаа бөгөөд цаашид Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар тодорхойлсон ижил зарчмаар буюу хөтөлбөрийн тавигдах шаардлага, бүтцийн хувь хэмжээг хуулийн зарчимд нийцүүлэн нарийвчлан тодорхойлох, хяналт тавих талаар холбогдох журмыг батлах эрхийг Үндэсний зөвлөлд олгож, Ерөнхий захирал нь уг журмын хүрээнд хөтөлбөр, нэвтрүүлэг, контент гаргах байдлаар зохицуулах нь оновчтой гэж үзэж байна.

#### 4. Харьцуулалт

Энэхүү хэрэгжилтийн үр дагаврын судалгааны хүрээнд харьцуулан судалсан Япон улсын NHK (Japan Broadcasting Corporation), Их Британийн BBC (British Broadcasting Corporation) болон БНСУ-ын KBS (Korean Broadcasting System) зэрэг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн радио, телевизүүдийн тухайд

44 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг дэлгэрэнгүй үзнэ үү.

45 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5



өдөр тутмын мэдээ, соёл, спорт, урлаг, кино суваг, олон улсын мэдээ, хөгжим гэх мэт олон суваг болон өөрийн салбарыг бусад улсад байршуулах хэлбэрээр өргөн хүрээнд хөтөлбөрөө олон нийтэд түгээж байна.

Тухайлбал, Их Британийн BBC-ийн тухайд есөн үндэсний телевизийн суваг (BBC One, BBC Two, BBC Three, CBBC, BBC News, BBC Parliament гэх мэт), 10 радио суваг, орон нутгийн телевизийн тухайд 50 гаруй телевиз болон радио, цахим платформын олон төрлийн үйлчилгээ (iPlayer, BBC Sounds, BBC Red Button гэх мэт), түүнчлэн дэлхий даяар 40 гаруй хэл дээр мэдээллийг телевиз, радио болон цахимаар түгээж байна.

БНСУ-ын KBS-ийн тухайд дараах сувгаар хөтөлбөрөө түгээдэг:

- Өргөн нэвтрүүлэг(지상파 방송)-ийн 2 суваг (KBS 1TV, KBS 2TV);
- Олон улсын 3 суваг(KBS World TV, KBS KOREA, KBS World Radio);
- Радио 6 суваг (KBS 1Radio, KBS 2Radio, KBS 3Radio, KBS 한민족 방송, KBS Classic FM, KBS Cool FM);
- Кабелийн 6 суваг (KBS N Sports, KBS Drama, KBS Joy, KBS Story, KBS Kids, KBS Life);
- DMB (Digital Multimedia Broadcasting)-ийн 4 суваг (U-KBS STAR, KBS HEART, KBS MUSIC) болон KBS+ зэрэг олон шинэ медиагаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Нэвтрүүлгийн хөтөлбөрийн бодлого, түүний агуулгыг тодорхойлохдоо аль ч улсын тухайд үндэсний соёл, урлаг, түүх хадгалж, түгээн дэлгэрүүлэх, үнэн зөв, бодит, мэдээллийг чанартай түргэн шуурхай хүргэх гэх мэт нөхцөлийг зааж өгсөн нь ОНРТТХ-ийн зохицуулалттай ижил төсөөтэй боловч эрхлэн гаргаж буй контентын чанарыг сайжруулах, хяналт тавих чиглэлээр ажилладаг зохион байгуулалтын бүтэц, нэгжийн тухайд ихээхэн ялгаатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.<sup>46</sup>

Тухайлбал, Япон улсын NHK-д дотоодын болон олон улсын нэвтрүүлгүүдийн чанарыг хянан сайжруулах зорилгоор 3 өөр чиг үүрэг бүхий зөвлөл Ерөнхийлөгчийн дор байгуулагдсан ажилладаг байна.<sup>47</sup>

## 5. Телевиз үзэлтийн тандан судалгаа

Монгол Улсад телевиз үзэлтийн тандан судалгааг эрхлэн гүйцэтгэж буй “Максима Медиа” ХХК-иас 2018, 2019, 2020 онд эрхлэн гүйцэтгэсэн телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлангаас үзвэл ОНРТ-ийн 1-р суваг буюу Үндэсний телевиз тогтмол өндөр хандалттай байсан судалгааны үр дүн гарсан байна.

### Хүснэгт 4 - 2018 оны ерөнхий рейтинг<sup>48</sup>

| Ранк | Телевиз, сувгийн нэр | Сувгийн төрөлжилт | Нэг үзэгчийн өдөрт зарцуулдаг хугацаа |
|------|----------------------|-------------------|---------------------------------------|
| 1    | Movie box            | Кино              | 60 мин                                |
| 2    | Боловсрол            | Өргөн нэвтрүүлэг  | 46 мин                                |

<sup>46</sup> Харьцуулсан судалгааны хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

<sup>47</sup> Бүтэц, чиг үүргийн схемийг харьцуулсан судалгааны ... талаас харна уу.

<sup>48</sup> “Максима Медиа” ХХК, Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан (УБ, 2018), 8



|   |       |                  |        |
|---|-------|------------------|--------|
| 3 | МҮОНТ | Өргөн нэвтрүүлэг | 46 мин |
|---|-------|------------------|--------|

**Хүснэгт 5 - 2019 оны ерөнхий рейтинг<sup>49</sup>**

| Ранк | Телевиз, сувгийн нэр | Сувгийн төрөлжилт | Нэг үзэгчийн өдөрт зарцуулдаг хугацаа |
|------|----------------------|-------------------|---------------------------------------|
| 1    | Movie box            | Кино              | 70 мин                                |
| 2    | МҮОНТ                | Өргөн нэвтрүүлэг  | 51 мин                                |
| 3    | Dream TV             | Хүүхэд            | 67                                    |

**Хүснэгт 6 - 2020 оны ерөнхий рейтинг<sup>50</sup>:**

| Ранк | Телевиз, сувгийн нэр | Сувгийн төрөлжилт | Нэг үзэгчийн өдөрт зарцуулдаг хугацаа |
|------|----------------------|-------------------|---------------------------------------|
| 1    | Movie box            | Кино              | 72 мин                                |
| 2    | Dream TV             | Хүүхэд            | 46 мин                                |
| 3    | МҮОНТ                | Өргөн нэвтрүүлэг  | 68 мин                                |

ОНРТ-ийн 1-р сувгийн хандалт судалгааны хугацаанд өндөр үзүүлэлттэй байсан боловч телевиз үзэгчид MNB-ийн нэвтрүүлгээс мэдээ, мэдээллийн хөтөлбөрийг үзэлтийг голчлон хүлээн авч үздэг буюу бусад хөтөлбөрийн хандалт бага талаар судалгааны үр дүнг харж болохоор байна.

“МҮОНРТ-ийн 2019-2023 оны стратеги төлөвлөгөө” нь MNB контент бүтээх, түүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд 1 дүгээр суваг буюу MNB Үндэсний телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн 35 хувь буюу 42 цагийг MNB контент эзэлж байгаа хэдий ч телевизийн ерөнхий рейтингд голлох нөлөө үзүүлж чадаагүй байна.<sup>51</sup>

<sup>49</sup> “Максима Медиа” ХХК, Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан (УБ, 2019), 8

<sup>50</sup> “Максима Медиа” ХХК, Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан (УБ, 2020), 8

<sup>51</sup> УИХТГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний газар, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан (УБ, 2022), 23-24



Телевизийн 1 дүгээр суваг буюу MNB Үндэсний телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн бүтэц:



Мөн тус судалгаагаар 2 дугаар суваг буюу Монголын мэдээ суваг нь ерөнхий рейтингээр 2018 онд 13 дугаарт, 2019, 2020 онуудад 12 дугаарт жагссан байна. Харин MNB Спорт, MNB Гэр бүл сувгууд ерөнхий рейтингээр эхний 20-н телевизийн жагсаалтад багтаагүй байна. Энэ нь шинэ сувгуудын хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагаа жигдрээгүй, мөн шинэ сувгуудын талаарх олон нийтийн мэдлэг, мэдээлэл бага байгаатай холбоотой гэж үзэж байна. MNB World сувгийн хувьд олон улсад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тул дотоодын хэрэглэгчдийн судалгаагаар тус сувгийн үйл ажиллагаа, чанар хүртээмжийг дүгнэх боломжгүй юм.<sup>52</sup>

Олон нийтийн телевизийн рейтинг өндөр үзүүлэлттэй гарахад өдөр тутмын мэдээ, олон ангит болон нэг ангит кино, түүх соёл, ёс заншилтай холбоотой хөтөлбөрүүд ихэнх хувийг эзэлж байгаа тул цаашид шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд гэх мэт хүүхэд залуучууд, нийгмийн олон зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн чанар, хүртээмжид анхаарах шаардлагатай байна.<sup>53</sup>

#### Хуралдааны тэмдэглэлээс<sup>54</sup>

Өнгөрсөн хугацаанд телевизийн 5 суваг, радиогийн 4 сувагтай болж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн нь үйл ажиллагаагаа өргөжүүлж байгаа хэлбэр хэдий болов чиг, энэ 9 сувгаа бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, чанартай нэвтрүүлэг, мэдээллийн хөтөлбөрүүд явуулах тал дээр хангалтгүй. Яагаад гэвэл хүчээ тарамдчихсан байна гэдгийг танай уран бүтээлчид ч уулзалт дээр хэлж байсан. Цөөхөн сувгаар чанартай нэвтрүүлгүүдийг маш сайн хийж явуулах уу. Олон суваг нэртэй ингэж нэг бие биеийнхээ сувгуудын нэвтрүүлгийг давтан гаргаж явах уу гэдэг дээрээ бол Үндэсний зөвлөл, гүйцэтгэх удирдлагын түвшинд, бодлогын түвшиндээ энийгээ бол эргэж харах шаардлагатай болсон байна гэдгийг хэлье.

<sup>52</sup> Мөн тэнд, 24

<sup>53</sup> Мөн тэнд, 26

<sup>54</sup> ОНРТ-ийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн үр дүнг танилцуулах Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022.04.20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс.





ОНРТ-ийн тухай үзэгчдийн байр суурийг тодруулсан ярилцлагад ч иргэд шинжлэх ухаан, танин мэдэхүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн олон зорилтот бүлэгт чиглэсэн контент гаргах, чанарыг сайжруулах, орчин үеийн залуучуудын хэрэгцээ шаардлага нийцүүлэх, цахим хэлбэрт шилжих шаардлагатай талаар санал, сэтгэгдлээ хуваалцсан байна.<sup>55</sup>

Түүнчлэн, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зөвлөмжид “...үндэсний эв нэгдэл, соёл, түүх, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, өв соёлоо гадаад, дотоодод эергээр сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлд түлхүү анхаарч нэвтрүүлгийн бодлогод тусгах талаар болон бусад өөрчлөлтүүдийг хуульд нэмж тусгах шаардлагатай. Тус хуулиар тодорхойлсон Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн өмчийн хэлбэр, эрх зүйн байдал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Улсын бүртгэлийн тухай хуулиудтай нийцүүлэх зайлшгүй шаардлагатай учраас энэ зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай байна”<sup>56</sup> гэснийг анхаарч, хууль тогтоомжийг боловсронгуй шаардлагатай байна.

---

<sup>55</sup> <https://www.polit.mn/a/104901> (сүүлд 2024.12.10-ны өдөр хандсан)

<sup>56</sup> Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022.04.20-ны өдрийн хуралдаанаас гарсан зөвлөмж.



### ТАВ. ОРОН НУТГИЙН ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ

|                             |                                                                                                                                                             |
|-----------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үнэлэх хэсэг                | <b>32 дугаар зүйл.</b> Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаа<br><b>33 дугаар зүйл.</b> Орон нутгийн радио, телевизийн хараат бус байдал |
| Томъёолсон шалгуур үзүүлэлт | Орон нутгийн радио, телевиз байгуулах шаардлага бий эсэх?                                                                                                   |

#### Үнэлгээ:

##### *Орон нутгийн радио, телевиз байгуулах шаардлага бий эсэх?*

ОНРТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1-т “Орон нутагт олон нийтийн радио, телевиз байж болно” гэж, энэ зүйлийн 32.2-д “Орон нутгийн радио, телевиз энэ хуульд заасан зарчмын дагуу байгуулагдаж, тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт үйлчилж, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаа явуулна” хэмээн орон нутагт ОНРТ-ийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлийг хуульчилсан байна.

ОНРТХ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл уг үндэслэлээр аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ОНРТ шинээр үүсгэн байгуулагдаагүй бөгөөд хүн ам ихээр төвлөрсөн аймаг, хотуудад байгуулах хэрэгцээ шаардлага гарч болох хуулийн эдгээр зохицуулалтыг хадгалах шаардлагатай.

ОНРТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Орон нутгийн радио, телевизийн ажиллах бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт болон үйл ажиллагаа явуулах журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэж заасан. Иймээс орон нутагт шинээр ОНРТ байгуулагдах тохиолдолд тухайн хуулийн этгээд нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т зааснаар өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцах ОНРТ-ээс тусдаа бие даасан хуулийн этгээд байхаар зохицуулжээ.

ОНРТ-ийн тухайд тухайн орон нутгийн телевиз, радиод үйл ажиллагааны талаар арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй оролцоно.



## ЗУРГАА.ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

### 1.ИХ БРИТАНИ | BBC



Их Британи | BBC

*British Broadcasting Corporation*

BBC буюу British Broadcasting Corporation (“**BBC**”) нь Их Британийн олон нийтийн санхүүжилт бүхий өргөн нэвтрүүлгийн систем юм. BBC нь анх 1922 онд British Broadcasting Company гэх нэртэй, зөвхөн Их Британийн үйлдвэрлэгчид хувьцааг нь эзэмших боломжтой хувийн корпорацийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Харин 1925 онд парламентын хорооны санал болгосноор British Broadcasting Company-г татан буулгаж оронд нь 1927 онд Их Британийн Хааны Дүрэм (“**Дүрэм**”)-ийн дагуу British Broadcasting Corporation хэмээх нэрээр одоогийн олон нийтийн санхүүжилт бүхий BBC-г байгуулсан.<sup>57</sup> Уг өөрчлөн байгуулалт нь

BBC-ын үйл ажиллагааг зохицуулсан гол баримт бичиг нь Дүрэм болон Суурь гэрээ бөгөөд BBC-ын үйл ажиллагаанд үйлчлэх хэд хэдэн хууль тогтоомж, дүрэм журам мөн бий. BBC-ын үйл ажиллагаатай холбоотой гол эрх зүйн баримт бичгүүдийг дор дурдав. Үүнд:

- Дүрэм | The Royal Charter<sup>58</sup> - Дүрэм нь BBC-ын эрх зүйн үндэс бөгөөд зорилго, нийтийн чиг үүрэг, үйл ажиллагаа, засаглал, шийдвэр гаргалт, жилийн төлөвлөлт, санхүүжилт, хяналт зэрэг суурь асуудлыг зохицуулсан.

Дүрмийг Их Британийн Соёл, хэвлэл мэдээлэл, спортын Төрийн нарийн бичгийн дарга Эрхэмсэг дээдсийн тушаалаар парламентад өргөн барьж, парламент тодорхой хугацаагаар баталдаг бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй ес дэх удаагийн Дүрэм нь 2016 онд батлагдан 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс 2027 оны 12-р сарын 31-ний хооронд үйлчлэх юм.

Арван жил хүчин төгөлдөр мөрдөгдсөн анхны дүрэм нь BBC-г боловсрол, зугаа цэнгээний хэрэглүүр болгон таниулсан бол 2007 онд батлагдсан дүрэм нь хамгийн сүүлийн үеийн технологийг хүргэх болон дижитал телевиз болох шилжилтэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн<sup>59</sup> зэргээр дүрэм бүр үйлчлэх хугацаандаа өөрийн гэсэн үүргийг гүйцэтгэж байв. Харин одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дүрэм (2016)-ын гол зохицуулалтууд нь BBC-д хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх OFCOM-ын чиг үүргийг тогтоосон, Засгийн газраас BBC-д тавих агуулгын шалгуурын талаар OFCOM-д зөвлөмж өгөх чиг

<sup>57</sup> Britannica, Keyword: BBC, Result: British Broadcasting Corporation (British Corporation), <https://www.britannica.com/money/British-Broadcasting-Corporation>, сүүлд 2024 оны 11 сарын 27-ны өдөр нэвтрэв.

<sup>58</sup> Copy of Royal Charter for the continuance of the British Broadcasting Corporation, 2016, [http://downloads.bbc.co.uk/bbctrust/assets/files/pdf/about/how\\_we\\_govern/2016/charter.pdf](http://downloads.bbc.co.uk/bbctrust/assets/files/pdf/about/how_we_govern/2016/charter.pdf)

<sup>59</sup> BBC, “The Royal Charter Archive”, <https://www.bbc.com/historyofthebbc/research/royal-charter>



үүрэгтэй болсон, BBC-ын зарлагад хяналт тавих Үндэсний Аудитын Газрын чиг үүргийг тогтоосон зэрэг байна.

- Суурь гэрээ | Framework Agreement<sup>60</sup> - Дүрмийн 53 дугаар зүйлд заасны дагуу холбогдох асуудлыг нарийвчлан зохицуулах үүднээс BBC нь Суурь гэрээг Их Британийн Соёл, хэвлэл мэдээлэл, спортын Төрийн нарийн бичгийн даргатай байгуулдаг.

Суурь гэрээ нь Дүрмийн зорилгод бүрэн нийцсэн байх ёстой бөгөөд BBC-ын үйл ажиллагаа буюу нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, арилжааны үйл ажиллагаа, олон улсын үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудал болон санхүүжилт, гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа зэргийг нарийвчлан зохицуулсан байдаг. Одоогийн хүчин төгөлдөр Суурь гэрээ нь 2016 онд Дүрэм шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор 2016 онд байгуулагджээ.

- Харилцаа холбооны тухай хууль<sup>61</sup> (2003) - Уг хууль нь харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх, зөвшөөрөл авах, харилцаа холбооны салбарын өрсөлдөөний зохицуулалт, ОФКОМ буюу Харилцаа холбооны албаны чиг үүргийг зохицуулсан.
- Телевизийн лицензийн журам<sup>62</sup> (2004) - Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Соёл хэвлэл мэдээлэл, спортын Төрийн нарийн бичгийн дарга уг журмын батлах бөгөөд уг журмаар телевизийн үйлчилгээний төлбөрийг тогтоодог.

### **Зорилго, нийтийн чиг үүрэг**

BBC-ын гол зорилго нь Дүрмийн 4 дүгээр зүйлд заасны дагуу “(i) эрхэм зорилгоо биелүүлэх, (ii) нийтийн чиг үүргийг сурталчлах явдал” байх бөгөөд уг хоёр зорилго нь BBC-ын бүхий л үйл ажиллагааны суурь байх тул дор дэлгэрүүлээ. Үүнд:

(i) BBC-ын эрхэм зорилго. Мэдээлэх, боловсрол олгох, зугаа цэнгэл олгох хүрээнд тэнцвэртэй, өндөр чанартай, бусдаас ялгарах бүтээл, үйлчилгээг үзэгчдэд хүргэх, нийтийн ашиг сонирхолд үйлчлэх.

(ii) BBC-ын нийтийн чиг үүрэг. BBC-ын нийтийн чиг үүргийг Дүрмийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тусгасан. Үүнд:

Хүмүүст дэлхий ертөнцийг ойлгох, харилцахад нь туслахын тулд тэнцвэртэй мэдээ, мэдээллээр хангах;

Бүх насны хүмүүсийн суралцахуйн явцыг дэмжих;

Бүтээлч, өндөр чанартай, ялгарахуйц үйлчилгээг үзүүлэх;

<sup>60</sup> Agreement, An Agreement Between Her Majesty's Secretary of State for Culture, Media and Sport and the British Broadcasting Corporation, 2016,

[https://downloads.bbc.co.uk/bbctrust/assets/files/pdf/about/how\\_we\\_govern/2016/agreement.pdf](https://downloads.bbc.co.uk/bbctrust/assets/files/pdf/about/how_we_govern/2016/agreement.pdf)

<sup>61</sup> Act, Communications Act, 2003, <https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/section/365>

<sup>62</sup> Regulation, The Communications (Television Licensing) Regulation, 2004 № 692 <https://www.legislation.gov.uk/uksi/2004/692/regulation/7>



Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын бүх үндэстний болон бүс нутгийн олон янз бүхий коммюнитиг илэрхийлэх, төлөөлөх, тэдэнд үйлчлэх, ингэхдээ Их Британийн бүтээлч эдийн засгийг дэмжих;

Их Британийн соёл, үнэт зүйлсийг таниулах.

### Үйл ажиллагаа

Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.a-f дэх хэсэгт BBC-ын эрхлэх 6 төрлийн үйл ажиллагааг тогтоож өгсөн бөгөөд үйл ажиллагаа бүрийг хэрхэн ойлгох, тэдгээрийг эрхлэхэд тавигдах шаардлага, хүрээ хязгаар зэргийг Дүрэм болон Суурь гэрээнд нарийвчлан тогтоож өгсөн байна. BBC-ын эрхлэх үйл ажиллагаа нь:

| Үйл ажиллагаа                                                                                          | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Их Британийн нийтэд чиглэсэн үйлчилгээ /Дотоодын үйлчилгээ   UK Public Services                        | Эрхэм зорилгоо биелүүлж, нэг буюу хэд хэдэн нийтийн чиг үүргийг сурталчлахуйц Суурь гэрээнд тусгасан одоогийн эрхэлж буй үйл ажиллагаа болон Их Британийн хэрэглэгчдэд зориулсан телевиз, радио, онлайн үйлчилгээнээс гадна хараахан нэвтрүүлээгүй байгаа бусад үйлчилгээ (Дүрмийн 7.3, Суурь гэрээний 7.1) буюу үндсэндээ Санхүүжилт хэсэгт дурдах телевизийн үйлчилгээ хамаарна.                                                                                                                                                                                                                                          |
| Олон Улсын үйлчилгээ   World Services                                                                  | Их Британиас гаднах хэрэглэгчдэд англи болон бусад хэлээр үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаа (Дүрмийн 7.4, Суурь гэрээний 33.2)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| Нэмэлт үйл ажиллагаа   Non-service Activities                                                          | Дотоодын үйлчилгээ болон Олон Улсын үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг идэвхижүүлэх, хоёрдогч шинж чанартай үйл ажиллагаа (Дүрмийн 7.5, Суурь гэрээний 16.2)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| Өөрийн охин компаниудаар дамжуулан хэрэгжүүлэх арилжааны шинжтэй үйл ажиллагаа   Commercial Activities | Дараах шаардлагыг хангасан BBC-ын нэр хүнд үнэ цэнийг алдагдуулахгүй, зах зээлийг гажуудуулж, шударга бус өрсөлдөөний давуу талыг бий болгохгүй зэрэг шаардлагыг хангасан <sup>63</sup> арилжааны үйл ажиллагааг BBC өөрөө бус өөрийн арилжааны үйл ажиллагаа эрхлэх охин компаниар дамжуулан эрхэлж болно <sup>64</sup> . Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- BBC-ын эрхэм зорилго болон нийтийн чиг үүрэгт нийцсэн;</li> <li>- Тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос шууд болон шууд бусаар хамааралгүй;</li> <li>- Ашиг олох зорилготой - арилжааны үр ашигтай.</li> </ul> (Дүрмийн 7.6, Суурь гэрээний 23.2) |

<sup>63</sup> (Орч.) Суурь гэрээний 23.5. Арилжааны үйл ажиллагаа явуулахдаа BBC дараах бүх шалгуурыг хангасан байх ёстой. Үүнд:

(а) үйл ажиллагаа нь эрхэм зорилго болон нийтийн чиг үүрэгт нийцсэн байх;

(б) үйл ажиллагаа нь арилжааны үр ашигтай байх;

(в) үйл ажиллагаа нь BBC-ийн нэр хүнд, үнэ цэнийг алдагдуулахгүй байх;

(г) үйл ажиллагаа нь зах зээлийг гажуудуулах, шударга бус өрсөлдөөний давуу талыг бий болгохооргүй байх. (эдгээрийн хамтад нь “арилжааны үйл ажиллагааны шалгуур” гэнэ).

<sup>64</sup> (Орч.) Суурь гэрээний 23.4. BBC нь корпорацын хувьд ямар нэгэн арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд нэг буюу хэд хэдэн арилжааны үйл ажиллагаа явуулах охин компаниар дамжуулан арилжааны үйл ажиллагааг эрхлэнэ.



|                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|---------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                               | <p>BBC-ын арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- BBC Worldwide Limited;</li> <li>- BBC Global News Limited;</li> <li>- BBC Studioworks Limited;</li> <li>- Шинээр байгуулсан бусад компани. (Суурь гэрээний 29.3)</li> </ul>                                                                                                                                                                                                            |
| Худалдааны үйл ажиллагаа   Trading Activities                 | <ul style="list-style-type: none"> <li>- BBC-ын хөрөнгө болон илүү хүчин чадлыг худалдах;</li> <li>- Зардал нөхөн зорилготой төлбөр;</li> <li>- Дотоодын болон Олон Улсын үйлчилгээний явцад үүссэн аливаа зүйлийн эрхийг борлуулах болон өөр аргаар захиран зарцуулах;</li> <li>- Дэд эрх борлуулах;</li> <li>- BBC-ын байгууллагууд хоорондын худалдаа;</li> <li>- BBC-ын контентод гуравдагч этгээд урьдчилан хөрөнгө оруулалт хийх.</li> </ul> <p>(Дүрмийн 7.7, Суурь гэрээний 31.2)</p> |
| Нарийвчилсан/Тусг айлсан үйл ажиллагаа   Specified Activities | <p>Суурь гэрээний 38-48 дугаар зүйлд заасан Уэлс, Шотланд, Умард Ирландад тус тусын хэлээр үйлчилгээ үзүүлэх, BBC мониторинг, Дижитал телевиз, Дижитал радио, өргөн зурвасыг нэвтрүүлэх, ашиглах зэрэг үйл ажиллагаа одоогоор үүнд хамаарч байна.</p> <p>(Дүрмийн 7.8, Суурь гэрээний 38-48)</p>                                                                                                                                                                                             |

## Санхүүжилт

BBC-ын санхүүжилтийн гол хэсгийг Харилцаа холбооны тухай хуулийн дагуу иргэдийн төлдөг телевизийн үйлчилгээний төлбөр бүрдүүлдэг бөгөөд үүнээс гадна арилжааны үйл ажиллагааны орлого, Олон Улсын үйл ажиллагаанд зориулж Засгийн газраас олгосон санхүүжилт болон бусад орлого нь үлдэх хэсгийг бүрдүүлдэг. Холбогдох хууль тогтоомж, Дүрэм, Суурь гэрээнд BBC-ын санхүүжилт, орлогын эх үүсвэрүүдийг шууд тусгайлан нэрлэн заагаагүй боловч дараах төрлийн санхүүжилт, орлогын эх үүсвэрүүд байна. Үүнд:

- Телевизийн үйлчилгээний төлбөр | TV licensing fee - Харилцаа холбооны тухай хуулийн 363 дугаар зүйлд заасны дагуу аливаа этгээд нь телевизийн үйлчилгээ авах бол үйлчилгээний төлбөрийг төлөх ёстой бөгөөд ийнхүү төлбөр төлөлгүйгээр телевизийн үйлчилгээ хүлээн авсан эсхүл төлбөрөө төлөөгүй тохиолдолд 1,000 хүртэлх фунт стерлингийн торгууль<sup>65</sup> төлөхөөс гадна хорих ял<sup>66</sup> ч хүртэл хүлээдэг байна. Телевизийн үйлчилгээ хүлээж авдаггүй өрхүүдийн хувьд уг төлбөрийг төлөх шаардлагагүй бөгөөд харин Телевизийн лицензийн агентлагт энэ талаараа бүртгүүлэх шаардлагатай байдаг.

<sup>65</sup> John Woodhouse, "TV licence fee non-payment: should it be decriminalised?", House of Commons Library, 2024, p.4  
<https://researchbriefings.files.parliament.uk/documents/SN06860/SN06860.pdf>

<sup>66</sup> John Woodhouse, "TV licence fee non-payment: should it be decriminalised?", House of Commons Library, 2024, p.8  
<https://researchbriefings.files.parliament.uk/documents/SN06860/SN06860.pdf>





Харилцаа холбооны тухай хуулийн 365 дугаар зүйлд заасны дагуу нарийвчилсан журам батлах замаар телевизийн үйлчилгээний төлбөрийг тогтоох эрхийг Соёл, хэвлэл мэдээлэл, спортын төрийн нарийн бичгийн даргад олгосон. Уг нарийвчилсан журам нь 2004 онд батлагдсан Телевизийн лицензийн журам<sup>67</sup> бөгөөд уг журмын Хавсралт 1-т 2024 оны 04 сарын 01-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу одоогоор телевизийн үйлчилгээний 1 жилийн төлбөр нь дараах байдалтай байгаа бөгөөд уг төлбөрийн хэмжээ багадаа 5 жил мөрдөгдөх юм. Үүнд:

| Хар цагаан       | Өнгөт               |
|------------------|---------------------|
| 57 фунт стерлинг | 169.5 фунт стерлинг |

Харилцаа холбооны тухай хуулийн дагуу телевизийн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх нөхцөл шаардлага, чөлөөлөгдөх хүмүүс зэргийг журамд тусгайлан зааж болох бөгөөд одоогийн хүчин төгөлдөр журмын дагуу хараагүй иргэд, 75 ба түүнээс дээш насны иргэдийг уг төлбөрөөс чөлөөлж байна. Уг чөлөөлөлтийн төлбөрийг мөн төрөөс BBC-д Суурь гэрээнд тохиролцсон дүнгээр төлдөг. (ХХтХ-ийн 363.6, Журмын 5, 6 дугаар зүйл, Суурь гэрээний 52 дугаар зүйл)

Телевизийн үйлчилгээний төлбөр хураах үйл ажиллагаа үр дүнтэй, зохистой пропорциональ байх ёстой бөгөөд телевизийн үйлчилгээний лицензийн хүсэлт хүлээн авах, бүртгэл хийх, төлбөрийг хүлээн авах, төлбөр төлөлтөд хяналт тавих зэрэг ажлыг Телевизийн лицензийн агентлаг<sup>68</sup> хэрэгжүүлдэг. Иргэд уг агентлагтай цахимаар, утсаар холбогдож эсхүл биечлэн очиж телевизийн үйлчилгээний төрөл, төлбөр төлөх нөхцөл зэргээ сонгодог. Телевизийн үйлчилгээ хүлээж авдаггүй этгээдүүдийн хувьд мөн уг агентлагт бүртгүүлдэг. (Дүрмийн 20.7.b)

Телевизийн үйлчилгээний төлбөрөөр дийлэнх санхүүжилтээ бүрдүүлэх нь зохистой эсэх талаар хэлэлцүүлгүүд сүүлийн жилүүдэд Их Британид өрнөж байгаа бөгөөд бусад санхүүжилтийн хэлбэрүүдийг судалсаар байна. Учир нь сүүлийн үеийн техник, технологи нь үзэгчид хэдийд ч, хаанаас ч аливаа контентыг үзэх боломжтой болгосонтой холбоотойгоор телевиз үзэхийн тулд төлбөр төлөх сонголтыг хийх өрхийн тоо буурч байгаа юм. Хэрэв энэ хандлага цаашид үргэлжилбэл телевизийн үйлчилгээний төлбөрийн тогтвортой байдалд хүндрэл учруулна.<sup>69</sup> Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дүрмийг батлах үеэр энэ асуудал хурцаар хөндөгдсөн бөгөөд 2027 онд Дүрмийн үйлчлэл дуусах үед телевизийн үйлчилгээний төлбөрийг цуцлах нь

<sup>67</sup> Regulation, The Communications (Television Licensing) Regulation, 2004 № 692 <https://www.legislation.gov.uk/ukxi/2004/692/schedule/1>

<sup>68</sup> TV Licensing Agency, <https://www.tvlicensing.co.uk/>

<sup>69</sup> Policy Paper, Department for Digital, Culture, Media & Sport, "Up next - the government's vision for the broadcasting sector", 2022, Chapter 2, <https://www.gov.uk/government/publications/up-next-the-governments-vision-for-the-broadcasting-sector/eaf7e080-5671-4bd0-b45e-fc6dfd9e6f63>



зайлшгүй талаар албаны хүмүүс ч мэдэгдэж байв.<sup>70</sup> Түүнчлэн, телевизийн үйлчилгээг төлбөр төлөлгүйгээр хүлээн авсан, төлбөрөө төлөөгүй тохиолдолд хорих ял оноож байгаа нь мөн зохисгүй талаарх саналууд хэлэлцэгдэж байгаа юм.<sup>71</sup>

- Олон Улсын үйл ажиллагааны санхүүжилт | World service supplementary funding - Суурь гэрээний 36 дугаар зүйлд заасны дагуу Олон Улсын тодорхой төслийг хэрэгжүүлэх зорилгоор Их Британийн Засгийн газраас тухай бүр нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулах замаар Олон Улсын үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийг BBC-д олгож болно.

Олон Улсын үйл ажиллагааны санхүүжилтийг BBC нь Гадаад хэргийн сайдтай тохиролцон тогтоодог. Тухайлбал, 2017-2022 онд жил бүрийн Олон Улсын үйл ажиллагааны санхүүжилтийн дээд хэмжээ 254 сая фунт стерлинг байв. (Суурь гэрээний 33.4, 33.5, 33.6)

- Арилжааны үйл ажиллагааны орлого - BBC нь өөрөө бус өөрийн арилжааны үйл ажиллагааг эрхлэх компаниар дамжуулан BBC-ын нэр хүнд үнэ цэнийг алдагдуулахгүй, зах зээлийг гажуудуулж, шударга бус өрсөлдөөний давуу талыг бий болгохооргүй арилжааны үйл ажиллагааг эрхлэн орлого олох боломжтой. Одоогийн хүчин төгөлдөр Суурь гэрээний 29.3-т зааснаар BBC болон Британийн бусад нэвтрүүлгийг гадаадад нэвтрүүлж, орлого олох зорилго бүхий BBC Worldwide Limited (кино, контент бүтээдэг BBC Studio үүнд хамаарна), BBC Global News Limited, BBC Studioworks Limited зэрэг нь BBC-ын арилжааны компаниуд юм. Мөн тодорхой арилжааны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор шинэ охин компани, хамтарсан компанийн BBC-ын Удирдах зөвлөл байгуулж болох бөгөөд уг үйл ажиллагаа нь дээр дурдсан шаардлагад нийцэж байгаа эсэхэд Соёл, хэвлэл мэдээлэл, спортын төрийн нарийн бичгийн дарга хяналт тавьдаг.
- Бусад орлого - Энэ хэсэгт дээр дурдагдаагүй бусад орлого хамаарна.

### Зарцуулалт

Дүрмийн 16 дугаар зүйлд олон нийт, төрөөс олгосон санхүүжилт, төлбөрийг захиран зарцуулахтай холбоотой дараах зарчмуудыг тогтоосон. Үүнд:

- Тогтмол байдал: BBC-ын бүхий л нөөцийг удирдаж буй үйл ажиллагаа нь Дүрэм, Суурь гэрээ болон бусад гэрээний заалтуудын дагуу байх ёстой.
- Зохист байдал: BBC-ийн бүхий л нөөцийг удирдаж буй үйл ажиллагаа нь зан үйлийн өндөр стандартад нийцсэн, сайн засаглалын зарчмуудыг хангасан байх ёстой бөгөөд BBC-д Парламентаас тогтоож буй хүлээлтийг харгалзан үзсэн байх ёстой.

<sup>70</sup> Media News, Dailymail, "The days of state-run TV are over": Nadine Dorries clobbers the BBC with a £2billion funding cut as she freezes the licence fee for two years, with a row over 'Left-wing bias' threatening to spill out into all-out war with the Corporation", 2022 <https://www.dailymail.co.uk/news/article-10406491/Nadine-Dorries-hits-BBC-2bn-funding-cut-freezes-annual-licence-fee-charge-2024.html>

<sup>71</sup> Policy Paper, Department for Digital, Culture, Media & Sport, "Up next - the government's vision for the broadcasting sector", 2022, Chapter 2, <https://www.gov.uk/government/publications/up-next-the-governments-vision-for-the-broadcasting-sector/eaf7e080-5671-4bd0-b45e-fc6dfd9e6f63>



- Үнэ цэнт байдал: Худалдан авалтын үйл ажиллагаа, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ системтэйгээр үнэлж дүгнэсэн байх бөгөөд ийнхүү үнэлэхдээ үр дүнтэй, нягт нямбай, чанартай, үнэ цэнтэй, аливаа алдаа, үрэлгэн байдлаас зайлсхийсэн, зөвхөн BBC-ын төдийгүй олон нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзсэн байх ёстой.
- Үндэслэлтэй байх: Төсвийн санхүүжилттэй үйл ажиллагаа үнэн зөвөөр төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх ёстой.


Харин Суурь гэрээний 49-55 дугаар зүйлд BBC-ын зарцуулалт, зарцуулалтад тавих хяналт, мөнгөн хөрөнгийн удирдлагатай холбоотой нарийвчилсан зүйлсийг зохицуулсан.

### Засаглал

BBC нь Дүрэм болон Суурь гэрээнд заасан зорилго, чиг үүргээ зохих ёсоор, үр дүнтэйгээр бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай чиг үүргийг хэрэгжүүлэх 14 гишүүн (Даргыг оролцуулаад)-ээс бүрдэх Удирдах зөвлөл ажилладаг.

Удирдах зөвлөл нь Дүрэм болон Суурь гэрээний дагуу BBC-ын стратегийн чиглэлийг тогтоох, Их Британийн нийтэд чиглэсэн үйл ажиллагаа болон Олон Улсын үйл ажиллагааны төсвийг батлах, BBC-ын редакцын болон бүтээлч үйлдвэрлэлийн стандартыг тогтоох, аливаа материаллаг өөрчлөлтийг шийдвэрлэх, хүний нөөц, санхүү, нийцлийн хувьд үр ашигтай бодлого хэрэгжүүлэх зэрэг бүрэн эрхтэй.

*Схем 1. BBC-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, томилгоо*



Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, томилгоотой холбоотой онцлох зүйлс.

**1.Олон талт, мэргэжлийн Удирдах зөвлөл.** BBC-ын Удирдах зөвлөл нь төрийн томилгооны зарчмыг баримтлан Засгийн газрын ахлах зөвлөхүүдийн зөвлөл ("33")-ийн шийдвэрээр томилсон Удирдах зөвлөлийн дарга болон Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын бүрэлдэхүүнд хамаарах Англи, Шотланд, Уэлс,




Умард Ирланд улсуудын холбогдох институтуудтай зөвшилцөж 33-өөс томилсон Үндэсний гишүүд, Удирдах зөвлөлөөс томилсон гүйцэтгэх бус чиг үүрэг бүхий гишүүд, Гүйцэтгэх захирал бөгөөд BBC-ын ерөнхий редактор болон гүйцэтгэх чиг үүрэг бүхий бусад гишүүдээс бүрдэнэ.

Гүйцэтгэх бус чиг үүрэг бүхий гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил бөгөөд 1 удаа улируулан сунгаж болно. Гүйцэтгэх бус чиг үүрэг бүхий гишүүдийн хувьд 33-өөс хэдийд ч томилгоог нь цуцалж болохоос гадна тухайн гишүүн дампуурсан, тасралтгүй 3 сарын хугацаанд Удирдах зөвлөлийн хуралд оролцоогүй, гүйцэтгэх бус чиг үүрэг бүхий гишүүдийн  $\frac{2}{3}$ -ын саналаар гэх мэт Дүрмийн 28 дугаар зүйлд огцруулах 10 орчим үндэслэл заасан.

Харин гүйцэтгэх чиг үүрэг бүхий гишүүдийн бүрэн эрхийн хугацаа болон цалин урамшуулал нь холбогдох гүйцэтгэх албан тушаалд томилохдоо тогтоосон нөхцөлийн дагуу байна.

**2.Удирдлагын бүтэц хоорондын уялдаа.** Ердийн байгууллагын хувьд (i) хувьцаа эзэмшигч/үүсгэн байгуулагч, (ii) хувьцаа эзэмшигч/үүсгэн байгуулагчдаас томилогдсон эсхүл мэргэжлийн этгээдүүдээс бүрдсэн удирдах зөвлөл, болон (iii) өдөр тутмын үйл ажиллагааг удирдах гүйцэтгэх удирдлагын баг гэсэн 3 тусдаа удирдлагын бүтэцтэй байдаг. BBC-ын хувьд гүйцэтгэх удирдлага нь Гүйцэтгэх захирал бөгөөд BBC-ын ерөнхий редактор болохын хувьд өөрийн үйл ажиллагааг Удирдах зөвлөлийн өмнө хариуцдаг этгээд байхаас гадна мөн Удирдах зөвлөлийнхөө нэг хэсэг болохоор байна.

*Схем 2. Удирдах зөвлөлийн дэргэдэх заавал байх хороод (Дүрэмд зааснаар)*



Дээрх схемд тусгасанчлан, Дүрэмд зааснаар BBC-ын Удирдах зөвлөл нь Аудит, эрсдэлийн хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин хөлсний хороог зайлшгүй байгуулах бөгөөд шаардлагатай бусад хороодыг байгуулж болно. BBC-ын 2023/24



оны жилийн тайланд дурдсанаар, BBC-ын Удирдах зөвлөл нь заавал байгуулах хорооноос гадна Шударга худалдааны хороо, Редакцын стандартын хороо, Англи, Шотланд, Умард Ирланд, Уэлсийн асуудал хариуцсан хороо зэрэг хороодтой байна.<sup>72</sup>

### Бүтээл/Контентын агуулгын шаардлага

BBC-ийн тэнцвэртэй, өндөр чанартай, бусдаас ялгарахуйц байдлыг хадгалах зорилгоор бүтээл/контентын агуулгад тодорхой шаардлага тавигддаг. Эдгээрийг багцалбал:

- Зохицуулалтын хяналт - ОФКОМ-ын хяналт<sup>73</sup> - ОФКОМ-ын зүгээс BBC-ын хөтөлбөр нь үзэгчдэд хэрэгцээгүй, хохирол учруулахуйц, хүчирхийлэл, доромжлол болон бусад ижил төстэй зүйлсэд уриалсан сэдэвтэй байгаа эсэхийг шалгадаг. Мөн аливаа бүтээлээр хүний хувийн нууц зөрчсөн эсэх, аливаа этгээдийг өөрт нь хохирол учруулахуйц байдлаар дүрслэн харуулсан зэрэг гомдлыг хүлээн авч хариу арга хэмжээ авдаг.
- BBC-ын редакцын удирдамж | Editorial Guidelines<sup>74</sup> - Редакцын удирдамж бол BBC-ын бүтээл/контентын агуулгын талаарх дотоод гол баримт бичиг юм. Уг удирдамжид агуулга үнэн зөв байх, аливаа алдаа гарсан бол нэн даруй залруулга хийх, арилжааны үйл ажиллагаа, улс төрийн болон хувийн ашиг сонирхлоос ангид, хараат бус ажиллах, аливаа нөлөөлөлд автахгүй байх, аливаа бүтээл/контент үзэгчдэд тохиромжтой байх буюу хүүхдэд тохиромжтой эсэхийг шалгах, тэнцвэртэй, мэдрэмжтэй байдлыг хангах зэрэг асуудлыг зохицуулсан байдаг.
- Арилжааны үйл ажиллагааны зохицуулалт - BBC-ын арилжааны үйл ажиллагаа нь тусдаа охин компаниудаар дамжин хэрэгждэг бөгөөд энэ үйл ажиллагааны агуулгад Их Британийн зар сурталчилгаатай холбоотой хууль тогтоомж, стандартууд тавигдана.

**Дүгнэлт:** Их Британийн олон нийтийн санхүүжилт бүхий өргөн нэвтрүүлгийн систем болох BBC нь байгуулагдаад 100 гаруй жил үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна. Засаглалын хувьд BBC-г удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл байх бөгөөд нийт 14 гишүүнтэй. Гэхдээ 14 гишүүдийн 10-ийг нь Гүйцэтгэх бус чиг үүрэг бүхий гишүүд, 4-ийг нь Гүйцэтгэх чиг үүрэг бүхий гишүүд гэж хуваана. Гүйцэтгэх чиг үүрэг бүхий 4 гишүүн болон Гүйцэтгэх бус чиг үүргийн бусад 5 гишүүдийг Гүйцэтгэх бус чиг үүрэг бүхий гишүүдээс томилдог нь Монгол улстай харьцуулахад тооны хувьд ойролцоо ч томилгооны хувьд онцлог бөгөөд тухайн улсын засаглалын онцлогоос ихээхэн хамааралтай байна.

<sup>72</sup> BBC, BBC Group Annual Report and Accounts 2023/24, 2024, p.103  
<https://www.bbc.co.uk/aboutthebbc/documents/ara-2023-24.pdf>

<sup>73</sup> OFCOM, "How Ofcom regulates the BBC", 2022  
<https://www.ofcom.org.uk/siteassets/resources/documents/consultations/category-2-6-weeks/222191-how-ofcom-regulates-the-bbc/associated-documents/how-ofcom-regulates-the-bbc.pdf?v=328093>

<sup>74</sup> BBC, Editorial Guidelines, 2019, <https://www.bbc.co.uk/editorialguidelines/guidelines>





Санхүүжилтийн тухайд Монгол Улстай ижил төсөөтэй байх боловч олон улсын санхүүжилтийг дурдахгүй өнгөрч болохгүй бөгөөд орчин үеийн техник технологийн өсөн дэвшилттэй холбоотойгоор санхүүжилтийн эх үүсвэр болох үйлчилгээний төлбөрийг хураахтай холбоотой асуудлууд тус улсад сүүлийн жилүүдэд газар авч байгаагаас үзвэл цаашид олон нийтийн тв-ийн санхүүжилтын эх үүсвэрт томоохон зарчмын шинжтэй өөрчлөлт орох магадлалтай байх ба үүнийг харгалзан үзэж болох юм.

Контентын тухайд BBC-ийн тэнцвэртэй, өндөр чанартай, бусдаас ялгарахуйц байдлыг хадгалах зорилгоор контентын агуулгад тодорхой шаардлагуудын хүрээнд ажилладаг бөгөөд эрх зүйн үндсийг холбогдох дүрэм, удирдамж, стандартуудаар нарийвчлан зохицуулдаг байна.

## 2.ЯПОН УЛС | NHK



### Япон Улс | NHK

*Japan Broadcasting Corporation*

NHK буюу “*Nippon Hoso Kyoka*” нь “*Japan Broadcasting Corporation*” гэсэн нэр бүхий Япон Улсын олон нийтийн телевиз юм (цаашид “**NHK**” гэх). Анх 1926 онд Токёо, Осака, Нагояа гэсэн гурван нэвтрүүлгийн станцыг нэгтгэж, хувийн компани үүсгэн байгуулагдсан ч 1950 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу олон нийтийн телевиз болж шинэчлэгдсэн<sup>75</sup>. Энэхүү шинэчлэлд Японы дайны дараах реформ болон ИБУИНХУ-ын “BBC” буюу олон нийтийн телевиз нөлөөлсөн бөгөөд улс төр, арилжааны нөлөөнөөс ангид соёлын болон бусад мэдээллийг хараат бусаар иргэдэд хүргэх зорилготой байсан.

1950 онд батлагдсан Японы Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар өргөн нэвтрүүлгийн харилцаа болох тусгай зөвшөөрөл, бүртгэл, өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа зэрэг суурь харилцаа болон олон нийтийн телевиз, нээлттэй их сургууль зэргийг зохицуулсан бөгөөд NHK-ийн засаглалын бүтэц, үйл ажиллагаа, санхүүжилт зэрэг суурь асуудлуудыг хамарчээ. Тус хуулийн 3.1.15-д зааснаар үндэсний олон нийтийн телевиз нь “Олон нийтийн сайн сайхны төлөө Япон улсын өнцөг булан бүрд хүлээн авах боломжтой, чанартай, баялаг нэвтрүүлгийн хөтөлбөр бүхий дотоодын үндсэн нэвтрүүлгийг (дотоодын нэвтрүүлгийг үндсэн нэвтрүүлэг гэж үзнэ) хэрэгжүүлж, нэвтрүүлэг болон түүний хүлээн авалтыг хөгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг явуулж, түүнчлэн олон улсын нэвтрүүлэг болон олон улсын хиймэл дагуулын нэвтрүүлгийг явуулах” зорилготой юм.

Хуульд NHK нь өөрийн дүрэмтэй байхаар заасан бөгөөд Удирдах зөвлөл дүрэмд дараах зүйлсийг зайлшгүй тусган баталж, өөрчлөлт оруулах тохиолдолд Дотоод хэргийн яамнаас зөвшөөрөл авахаар заасан. Үүнд:

#### 1. Зорилго;

<sup>75</sup> NHK Албан ёсны цахим хуудас - <https://www.nhk.or.jp/corporateinfo/about/history.html>;





2. Нэр;
3. Хаяг;
4. Хөрөнгө болон дансны мэдээлэл;
5. Удирдах зөвлөл, Аудитын хороо, Гүйцэтгэх зөвлөл, бүрэлдэхүүний мэдээлэл;
6. Үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, удирдамж;
7. Өргөн нэвтрүүлгийн бонд гаргахтай холбоотой журам;
8. Олон нийтэд мэдэгдэл хүргэх журам.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиас гадна NHK-ийн Дүрэм нь үйл ажиллагааны бас нэгэн эрх зүйн эх сурвалж болж байгаа бөгөөд Японы үндэсний олон нийтийн телевизийн үйл ажиллагааны суурь үндэслэл, бүтэц зохион байгуулалт, үүрэг хариуцлагыг тодорхойлох чухал ач холбогдолтой.

### Засаглал

NHK-ийн эрх барих дээд байгууллага нь “Удирдах Зөвлөл” бөгөөд байгууллагын дүрэм, бодлого, жилийн санхүүжилт болон үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг тодорхойлж, батлах, гүйцэтгэлийг хянах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Бүтцийн хувьд Удирдах зөвлөлийн доор “Аудитын хороо”, “Гүйцэтгэх зөвлөл” болон Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах бөгөөд Аудитын хороо нь бусад бүтцээс хараат бусаар байгууллагын үйл ажиллагааг хянаж, Удирдах зөвлөлд тайлагнах чиг үүрэгтэй<sup>76</sup> бол Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч, бусад үйл ажиллагаа хариуцсан захирлууд нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг хүлээдэг. Харин Дүрэмд заасан чухал үйл ажиллагааг хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл “Гүйцэтгэх Зөвлөл” хэлбэрээр үйл ажиллагааг хэлэлцэхээр заажээ<sup>77</sup>. Засаглалын зураглал, тэдгээрийн доторх бүтцийг доор зурагт харуулав.

<sup>76</sup> Японы Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 43 дугаар зүйл. Аудитын хороо нь удирдах ажилтнуудын үүргийн гүйцэтгэлийг хянах үүрэгтэй.

In English: Article 43. The Audit Committee is to audit the performance of duties of the officers.

日本語で: 監査委員会は、役員の仕事の執行を監査する。


<sup>77</sup> Японы Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 50.2. Гүйцэтгэх зөвлөл нь дүрэмд заасны дагуу чухал үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хэлэлцэнэ.

In English: Article 50 (2). The Council is to discuss the performance of the important operations of NHK pursuant to the provisions of the articles of incorporation.

日本語で: 理事会は、定款の定めるところにより、協会の重要業務の執行について審議する。



Схем 3. NHK-ийн засаглалын зураглал



Удирдах зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо, олонхын саналаар сонгох бөгөөд тус нэгж нь Хуулийн 29 дүгээр зүйлд заасан дараах шийдвэрүүдийг гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. NHK-ийн удирдлагын бодлогыг тодорхойлох;
2. Аудитын хорооны үйл ажиллагаанд шаардлагатай, Дотоод хэргийн яамны тушаалаар тогтоосон асуудлууд;
3. Үйл ажиллагааны зохистой байдлыг хангах шаардлагатай системүүдийн хөгжүүлэлт. Тухайлбал, Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, захирлуудын үүргийн гүйцэтгэл нь хууль тогтоомж болон дүрэмд нийцэж байгаа эсэх нийцлийн систем;
4. Орлого, зарлагын төсөв, бизнесийн болон санхүүжилтийн төлөвлөгөө;
5. Үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан;
6. Радио, телевизийн станц байгуулах, ашиглалтад оруулах, зогсоох, татан буулгах төлөвлөгөө;
7. Хөтөлбөрийн стандарт, нэвтрүүлгийн агуулгын үндсэн төлөвлөгөө;
8. Дүрэмд өөрчлөлт оруулах;
9. Чухал үл хөдлөх хөрөнгө олж авах, борлуулах талаарх үндсэн асуудлууд;
10. Гадаадын нэвтрүүлгийн байгууллагуудтай хамтран ажиллах асуудлууд.



ННХ-ийн засаглалын бүтцэд бусдаасаа хараат бусаар, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэгж нь Аудитын хороо бөгөөд албан тушаалтан болон ажилтнуудын үүргийн гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор тэдний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл, тайланг шаардах, ННХ-ийн болон охин компаниудын үйл ажиллагаа болон эд хөрөнгийн мэдээллийг хэдийд ч шаардах эрхтэй онцгой нэгж бөгөөд үр дүн, гарсан зөрчлийг Удирдах Зөвлөлд шууд тайлагнах үүрэг хүлээдэг.

Харин Ерөнхийлөгчийн хувьд ННХ-ийг төлөөлөх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Удирдах Зөвлөлийн шийдвэрийг дагаж, мөрдүүлэх чиг үүрэг бүхий субъект<sup>78</sup> бол түүний эзгүйд түүнийг орлох болон үйл ажиллагаанд нь туслах чиг үүргийг Дэд ерөнхийлөгч хүлээдэг.

### Санхүүжилт

ННХ нь жил бүрийн санхүүгийн орлого, зарлагын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөрөнгийн төлөвлөгөөг боловсруулан, Дотоод хэргийн сайдад танилцуулах, үүнийг өөрчлөх шаардлагатай тохиолдолд мөн адил журмыг мөрдөх үүргийг хүлээдэг /70.1/. Дотоод хэргийн яам ийнхүү хүлээж авч, хянаад Парламентад танилцуулж, батлуулснаар ННХ-ийн жилийн санхүүгийн төлөвлөгөө эцэслэн батлагддаг /70.2/.

ННХ нь олон нийтийн телевиз болохын хувьд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах, хуульд заасан үндсэн болон нэмэлт үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд зардал гаргахыг хориглодог /73.1/. Харин орлогын хэд хэдэн төрөлтэй хэдий ч хэрэглэгчдийн төлсөн төлбөр нь орлогыг бараг 100 хувь бүрдүүлдэг байна. Санхүүжилтийн төрлийг ангилан үзвэл:

| № | Санхүүжилтийн төрөл     | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|---|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Үйлчилгээний төлбөр     | ННХ-ийн нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой хүлээн авах төхөөрөмж суурилуулсан хэрэглэгч нь ННХ-тэй “Хүлээн авах гэрээ” байгуулах ёстой бөгөөд энэхүү гэрээний дагуу үйлчилгээ төлбөрийг ННХ-д төлөх үүрэгтэй /64.1/.<br><br>Хэрэглэгчээс хураах хураамжийн сарын хэмжээг Парламентаас ННХ-ийн жилийн орлого, зарлагын хэмжээг батлахдаа тогтооно. |
| 2 | Өргөн нэвтрүүлгийн бонд | ННХ нь нэвтрүүлгийн тоног төхөөрөмжийг барьж байгуулах эсхүл засварлах санхүүжилтийг босгох зорилгоор бонд гаргаж болно /80.1/. Бондын нийт дүн нь тухайн жилийн санхүүгийн шалгалтаар баталгаажсан                                                                                                                                               |

<sup>78</sup> Японы Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 51.1. Ерөнхийлөгч нь ННХ-г төлөөлж, Удирдах зөвлөлийн тогтоосон журмын дагуу үйл ажиллагааг удирдан зохион байгуулна..

In English: Article 51 (1). The President is to represent NHK and preside over its operations in accordance with the decisions of the Board of Governors.

日本語で: 副会長は、会長の定めるところにより、協会を代表し、会長を補佐して協会の業務を掌理し、会長に事故があるときはその職務を代行し、会長が欠員のときはその職務を行う。



|   |                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|---|------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                                          | санхүүгийн баланс дахь цэвэр хөрөнгийг гурав дахин ихэсгэсэн хэмжээнээс хэтэрч болохгүй /80.2/.                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| 3 | Төрөөс санхүүжүүлэх зардал               | <p>ННХ-ийн дараах зардлыг хуульд заасны дагуу төр хариуцна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дотоод хэргийн яамны хүсэлтийн дагуу хэрэгжүүлж буй олон улсын өргөн нэвтрүүлгийн эсхүл олон улсын хиймэл дагуулын өргөн нэвтрүүлгийн зардал;</li> <li>• Дотоод хэргийн яамны тушаалын дагуу гүйцэтгэж буй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний сайжруулалттай холбоотой судалгааны зардал;</li> </ul> |
| 4 | Арилжааны шинжтэй үйл ажиллагааны орлого | ННХ нь ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг хэдий ч үйл ажиллагааны санхүүжилтийг нөхөх зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаатай холбоотой бүтээгдэхүүн, хөтөлбөр, үйлчилгээг борлуулж болно.                                                                                                                                                                                                                  |
| 5 | Бусад орлого                             | Үүнд ННХ-ийн оюуны өмчийг борлуулах болон бусад байгууллагатай хамтран ажилласны үр дүнд бий болсон орлого зэрэг орж болно.                                                                                                                                                                                                                                                                                      |

Үйлчилгээний төлбөр (2023 оны 10 дугаар сарын байдлаар татвар багтсан дүн):

| <i>Гэрээний төрөл</i>                 | <i>Төлбөрийн дүн<br/>(сараар)</i> | <i>Төлбөрийн дүн<br/>(6 сараар)</i> | <i>Төлбөрийн дүн<br/>(жилээр)</i> |
|---------------------------------------|-----------------------------------|-------------------------------------|-----------------------------------|
| Суурин хүлээн авагчийн гэрээ          | ¥1,100                            | ¥6,309                              | ¥12,276                           |
| Хиймэл дагуулын хүлээн авагчийн гэрээ | ¥1,950                            | ¥11,186                             | ¥21,765                           |

ННХ нь бизнесийн борлуулалттай холбоотой зар сурталчилгаа дамжуулахыг хуулиар хориглодог /83.1/ боловч хөтөлбөрийн редакцын шаардлагаар, борлуулалтын зар сурталчилгааны зорилгогүйгээр зохиогчийн эсхүл бизнес эрхлэгчийн нэр болон бусад мэдээллийг дамжуулахыг зөвшөөрдөг /83.2/.

#### **Олон нийтийн телевизийн үйл ажиллагааны зохицуулалт:**

ННХ нь радио, телевизийн нэвтрүүлгийг Япон даяар хүртээмжтэй хүргэх үүрэгтэй тул дараах үндсэн болон нэмэлт үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд эдгээр үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус байна.



| <b>Үндсэн үйл ажиллагаа</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                      |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Радио, телевизийн дотоодын үндсэн нэвтрүүлэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• АМ радио</li> <li>• FM радио</li> <li>• Телевизийн өргөн нэвтрүүлэг</li> </ul> |
| Хиймэл дагуулын үндсэн өргөн нэвтрүүлэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | NHK-ээс бусад байгууллагуудын хиймэл дагуулыг ашиглан телевизийн нэвтрүүлэг хүргэх үйл ажиллагаа                                     |
| Судалгаа, шинжилгээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Өргөн нэвтрүүлэг, радио долгионы хүлээн авалтыг сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээ гүйцэтгэх ажиллагаа                         |
| Олон улсын өргөн нэвтрүүлэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Япон болон гадаадын иргэдэд зориулсан олон улсын радио, телевизийн нэвтрүүлгийн үйл ажиллагаа                                        |
| Олон улсын хиймэл дагуулын нэвтрүүлэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Япон болон гадаадын үзэгчдэд зориулсан NHK-ийн олон улсын хиймэл дагуулын телевизийн нэвтрүүлэг                                      |
| <b>Нэмэлт үйл ажиллагаа</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                      |
| <ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын нэвтрүүлгийг гадаадын байгууллагуудын дамжуулах станцаар дамжуулах;</li> <li>• NHK-ийн нэвтрүүлэг болон холбогдох мэдээллийг цахим шугамаар хүргэх;</li> <li>• Нэвтрүүлгийн материал болон бусад мэдээллийг гадаадын байгууллагуудад өгөх;</li> <li>• Өргөн нэвтрүүлгийн тоног төхөөрөмж түрээслэх;</li> <li>• Техникийн туслалцаа, сургалт зохион байгуулах;</li> </ul> |                                                                                                                                      |


NHK нь дотоод болон олон улсын нэвтрүүлгийн агуулгыг тодорхойлохдоо дараах шаардлагуудыг үндсэн чиглэл болгодог. Үүнд:

- Олон нийтийн хэрэгцээг хангах: Өндөр чанартай, баялаг нэвтрүүлгийг хүргэж, соёлын түвшинг дээшлүүлэхэд анхаарах.
- Орон нутгийн онцлогийг харгалзах: Улсын хэмжээний нэвтрүүлгээс гадна орон нутгийн онцлогт нийцсэн нэвтрүүлгүүд бэлтгэх.
- Үндэсний соёлыг хадгалж, дэлгэрүүлэх: Үндэсний соёлын өвийг хадгалах, шинэ соёлыг хөгжүүлэх, дэлгэрүүлэх ажлыг дэмжих.
- Нийгмийн хэрэгцээг тодорхойлох: Олон нийтийн санал бодлыг тогтмол судалж, үр дүнг нийтэд мэдээлэх.
- Гадаадад чиглэсэн нэвтрүүлэг бэлтгэхдээ (1) Гадаадад байгаа Япон иргэдэд зориулан мэдээллийн болон хөгжөөнт нэвтрүүлгүүд бэлтгэх; (2) Гадаад үзэгчдэд зориулан Японы соёл, аж үйлдвэр, бусад онцлогийг таниулах замаар олон улсын харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих.
- Гадаадын телевизийн станц ашиглан нэвтрүүлэг хийхдээ тухайн улс орны соёлын онцлогийг харгалзан ажиллах.



ННК-ийн дотоодын болон олон улсын нэвтрүүлгүүдийн чанарыг хянан сайжруулах зорилгоор 3 өөр чиг үүрэг бүхий зөвлөл Ерөнхийлөгчийн дор байгуулагдсан ажилладаг. Доорх зурагт бүтэц, чиг үүргийг харуулав.

**Схем 4. ННК-ийн Хөтөлбөр хариуцсан зөвлөлүүдийн зураглал**



ННК нь бүс нутгийн нэвтрүүлгийн төлөвлөгөө гаргахдаа Орон нутгийн зөвлөлтэй зөвлөлдөх ёстой. Мөн зөвлөлүүд нь ННК-ийн хөтөлбөрийн талаар санал гаргах эрхтэй.

**Дүгнэлт:** Япон Улсын үндэсний олон нийтийн телевиз болох ННК нь байгуулагдаад 100 дахь жилдээ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж буй олон нийтийн телевиз юм. Анх зөвхөн дотоодын иргэдийг телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөрөөр хангаж байсан бол өдгөө NHK World сувгаар үйл ажиллагаагаа тэлж, олон улсын түвшинд олон төрлийн телевизийн хөтөлбөрийг бэлтгэн хүргэдэг, 11,000 гаруй ажилтантай ажээ.

Японы олон нийтийн телевиз болох ННК-ийн засаглалын бүтцийг Монголын олон нийтийн радио телевизийн удирдлагын бүтэцтэй харьцуулан үзвэл гүйцэтгэх удирдлагын багийн бүтэц нь маш том бөгөөд энэ тус байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, байгууллагын хэмжээ, ажиллагсдын тоо зэргээс хамааралтай байж болох юм. Харин бусад нэгжийн хувьд Удирдах зөвлөл, Аудитын хороо зэрэг нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан Үндэсний зөвлөл, Хяналтын зөвлөлийн чиг үүрэгтэй төстэй хэдий ч зөвлөлийн гишүүдийг томилж буй этгээд, бүрэн эрхийн хугацаа нь ялгаатай байна.





Харин санхүүжилт болон үйл ажиллагааны хувьд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар “зар сурталчилгааны үйл ажиллагаа” эрхлэхийг хориглодог бөгөөд NHK-ийн үйл ажиллагаа нь зөвхөн нийтийн ашиг сонирхлын тулд, ашгийн төлөө бус байх ёстой. Ийм ч учраас санхүүжилтийн бараг 100 гаруй хувийг зөвхөн хэрэглэгчдийн төлсөн төлбөрөөр бүрдүүлдэг байна. Харин манай улсын хувьд Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд зааснаар олон нийтийн радио, телевиз нь “зар сурталчилгаа”-аас орлого болох боломжтой байгаа нь ихээхэн ялгаатай байна. Тодруулбал, NHK нь ашгийн төлөө бус олон нийтийн телевиз тул ашгийн төлөөх үйл ажиллагаа явуулахгүй байхаар хуульд заасан байтал манай улсын эрх зүйн зохицуулалтын хувьд мөн адил “гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд” гэж заасан хэдий ч “зар сурталчилгаа”-ны үйл ажиллагаа явуулж болохоор зохицуулжээ.

Дээрхээс гадна, NHK нь дотоодын болон олон улсын нэвтрүүлгүүдийн чанарыг хянан сайжруулах зорилгоор 3 өөр чиг үүрэг бүхий зөвлөл үйл ажиллагаа явуулдаг бол энэ чиг үүргийг Монгол Улсын хувьд зөвхөн Ерөнхий захирлын чиг үүрэг байхаар хуульд заажээ. Тухайлбал, хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6.2-т “энэ хуулиар тодорхойлсон хөтөлбөрийн бодлогын хүрээнд нэвтрүүлгийн хөтөлбөрийг тогтоох” гэж заасан байна. Энэ нь үндэсний олон нийтийн радио телевизийн хөтөлбөр нь нэг субъектээс хэт хамааралтай байх сөрөг үр дагавартай байж болох юм.



### 3.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС | KBS



Бүгд Найрамдах Солонгос Улс | KBS

*Korean Broadcasting System*

#### ***KBS-ийн тухай***

Солонгосын олон нийтийн радио, телевиз болох KBS (Korean Broadcasting System=한국방송공사, 공영방송) нь 1927 онд **Кёнсон нэвтрүүлэх станц** нэртэйгээр Солонгост анх удаа радио нэвтрүүлгээ дамжуулж эхэлсэн бөгөөд Японы колоноос чөлөөлөгдсөний дараа 1947 онд дахин **“Сөүлийн төв радио”**-оор ажиллаж эхэлсэн.

1961 оноос эхлэн телевизийн нэвтрүүлэг дамжуулж эхэлсэн бөгөөд 1973 онд **Солонгосын өргөн нэвтрүүлгийн олон нийтийн байгууллага** нэртэй болж олон нийтийн радио, телевизийн системээр өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

KBS нь:

1. Өргөн нэвтрүүлэг(지상파 방송)-ийн 2 суваг (KBS 1TV, KBS 2TV),
2. Олон улсын 3 суваг(KBS World TV, KBS KOREA, KBS World Radio),
3. Радио 6 суваг (KBS 1Radio, KBS 2Radio, KBS 3Radio, KBS 한민족 방송, KBS Classic FM, KBS Cool FM),
4. Кабелийн 6 суваг (KBS N Sports, KBS Drama, KBS Joy, KBS Story, KBS Kids, KBS Life)
5. DMB(Digital Multimedia Broadcasting)-ийн 4 суваг (U-KBS STAR, KBS HEART, KBS MUSIC) болон KBS+ зэрэг олон шинэ медиагаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Төв оффис нь Сөүл хотын Ёндёнпо дүүргийн Ёуидо-донг хотод байрладаг бөгөөд улсынхаа гол 9 бүсэд салбартай, тусдаа орон нутгийн 9 радио, тв-тэй, мөн АНУ, Европ, Хятад, Япон зэрэг 5 тивийн 11 улсад салбартай бөгөөд тусгай эрх бүхий сурвалжлагчид байнгын оршин сууж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.

KBS нь соёл урлагийг сурталчлах зорилгоор 1600 гаруй хүний суудалтай KBS танхимтай бөгөөд тус танхимд KBS симфони найрал хөгжмийн чуулга, KBS Солонгосын уламжлалт найрал хөгжмийн чуулга үйл ажиллагаагаа явуулдаг. Түүнчлэн уулархаг болон алслагдсан газруудад долгионы алдагдлыг арилгахын тулд хичээн ажиллаж, дараагийн үеийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг удирдан



чиглүүлэх, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор тасралтгүй судалгаа, төслүүдийг хэрэгжүүлдэг.<sup>79</sup>

## **KBS-д холбогдох хууль, эрх зүйн үндэслэл**

### **2.1. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль**

БНСУ нь үйл ажиллагаа явуулж байгаа бүх өргөн нэвтрүүлгийн радио, тв-үүдийн эрх зүйн харилцааг 1987 оны 12-р сарын 04-ны өдөр батлагдаж, 2000 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр шинэчлэгдсэн **Өргөн нэвтрүүлгийн тухай хууль**/цаашид “ӨНТХ” гэх/-иар зохицуулдаг. Тус хуулийн зорилгыг “ .... өргөн нэвтрүүлгийн эрх чөлөө, хараат бус байдлыг баталгаажуулж, нийтийн чиг үүргийг нэмэгдүүлэх замаар үзэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, ардчилсан олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх, үндэсний соёлыг дээшлүүлэх, өргөн нэвтрүүлгийн хөгжил болон олон нийтийн сайн сайхны төлөөх үйлсэд хувь нэмрээ оруулахад оршино.” хэмээн тодорхойлсон.

ӨНТХ-ийн 4 дүгээр бүлэг буюу **“Солонгосын нэвтрүүлгийн олон нийтийн байгууллага”** бүлгээр KBS-ийн эрх зүйн үндсийг зохицуулсан. *ӨНТХ-ийн 43-р зүйлийн 43.1 дэх хэсэгт* “Шударга, зөв боловсон нэвтрүүлгийн соёлыг суурьшуулах, дотоод, гадаадын өргөн нэвтрүүлгийг үр нөлөөтэй дамжуулах зорилгоор **Солонгосын өргөн нэвтрүүлгийн олон нийтийн байгууллагыг** улсын гол олон нийтийн байгууллага болгон байгуулав.” хэмээн эрх зүйн үндэслэлийг тодорхойлж өгсөн. KBS-ийн үндсэн хөрөнгө нь 300 тэрбум байх бөгөөд хөрөнгө оруулагч нь Засгийн газар байна.

### **ӨНТХ-ийн 44 дүгээр зүйл. Нийтийн чиг үүрэг**

1. KBS нь өргөн нэвтрүүлгийн зорилго, олон нийтийн хариуцлага, өргөн нэвтрүүлгийн шударга байдал, нийтийн ашиг сонирхлыг бодитойгоор хэрэгжүүлнэ.
2. KBS нь бүс нутаг, орчны нөхцөл байдлаас үл хамааран иргэдэд чанартай өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг үзүүлэхийг хичээх ёстой.
3. KBS нь үзэгчдийн нийтийн ашиг сонирхолд хувь нэмрээ оруулах өргөн нэвтрүүлгийн шинэ хөтөлбөр, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, өргөн нэвтрүүлгийн технологийг судалж, хөгжүүлнэ.
4. KBS нь үндэсний соёлыг сурталчлах, үндэсний нэгдмэл байдлыг хангасан өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр боловсруулж гадаад, дотоодод нэвтрүүлнэ.
5. KBS нь бүс нутгийн өргөн нэвтрүүлгийн олон талт байдлыг агуулсан, орон нутгийн иргэдийн тэнцвэртэй хөгжилд хувь нэмэр оруулах сайн чанарын хөтөлбөрүүдийг боловсруулж, нэвтрүүлнэ.

### **2.2. KBS-ийн дүрэм**

**KBS-ийг үүсгэн байгуулах дүрэмд дараах зүйлийг тусгана. Үүнд:**

- Зорилго
- Байгууллагын нэр
- Төв оффисын хаяг

<sup>79</sup> <https://about.kbs.co.kr/index.html?sname=kbs&style=introduce>



- Байгууллагын бүтэц, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд, гүйцэтгэх байгууллага болон ажилчид
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд
- Чиг үүрэг болон гүйцэтгэлтэй холбоотой асуудлууд
- Үзэгчдийн гомдлыг шийдвэрлэх, үзэгчийг хамгаалахтай холбоотой асуудлууд
- Үндсэн дүрмийн өөрчлөлттэй холбоотой асуудлууд
- Бонд гаргах, зээл авахтай холбоотой асуудлууд
- Хувьцаа болон хөрөнгө оруулалтын баталгаатай холбоотой асуудлууд
- Ашиг, алдагдлыг боловсруулах зэрэг санхүүтэй холбоотой асуудлууд
- Нийтэд зарлах асуудал
- Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад асуудал

KBS нь Үндсэн дүрмийг өөрчлөхийг хүсвэл БНСУ-ын Харилцаа, холбооны хороо(한국방송통신위원회)-оос зөвшөөрөл авах бөгөөд хороо нь хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэхээ KBS-д мэдэгдэнэ. Хэрэв заасан хугацаанд зөвшөөрөл олгох болон Иргэний гомдол хянан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу хугацааг сунгах талаар KBS-д мэдэгдээгүй бол уг хугацаа дууссан өдрийн дараагийн өдөр зөвшөөрөл олгогдсонд тооцдог.

## **Засаглал**

### **1.Төлөөлөн удирдах зөвлөл**

ӨНТХ-ийн 46-р дугаар зүйлд заасны дагуу KBS-ийн бие даасан байдал болон олон нийтийн шинжийг хангахын тулд KBS-ийн удирдах дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл /Цаашид “Удирдах зөвлөл” гэх/ байна.

Удирдах зөвлөл нь нийт орон тооны бус 11 гишүүнтэй. Гишүүдийг салбар бүрийн төлөөллийг харгалзан Солонгосын Харилцаа, холбооны хорооноос санал болгож, Ерөнхийлөгч 3 жилийн хугацаатай томилдог. Удирдах зөвлөлийн даргыг Удирдах зөвлөлөөс сонгох бөгөөд Удирдах зөвлөлийг хуралдуулж, хурлын даргаар ажиллана. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд дүрэмд заасан гишүүн орлож хуралдааныг даргална.

Удирдах зөвлөлийн хурал олон нийтэд нээлттэй явагдана. Гэхдээ дараах тохиолдлуудад Удирдах зөвлөлийн шийдвэрээр хаалттай явуулж болно. Үүнд:

- Нууцын зэрэглэлд хамаарах болон бусад хууль, журмын дагуу задруулахыг хязгаарласан аливаа асуудал багтсан тохиолдолд;
- Нээлттэй хурал нь хувь хүн, ААН, байгууллагын нэр хүндэд халдах, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл;
- Аудит, боловсон хүчний удирдлага зэрэгтэй холбоотой асуудлыг задруулах нь үүргээ шударгаар биелүүлэхэд ихээхэн саад учруулж болзошгүй тохиолдолд хуралдааныг хаалттай явуулна.

Гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд тухайн орон тоо гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор орлон гүйцэтгэгчийг томилох ёстой бөгөөд орлон гүйцэтгэгчийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь өмнөх гишүүний бүрэн эрхийн



үлдсэн хугацаатай тэнцүү байна. Бүрэн эрхийн хугацаа нь дууссан гишүүн нь дараагийн гишүүнийг томилох хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

**Удирдах зөвлөл нь дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:**

- KBS-ээс явуулж буй өргөн нэвтрүүлгийн нийтийн чиг үүрэгтэй холбоотой асуудал
- KBS-ээс явуулж буй өргөн нэвтрүүлгийн үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Төсөв, хөрөнгийн төлөвлөгөө
- Нөөц хөрөнгийн ашиглалт болон төсвийн шилжүүлэг
- Тайлан
- KBS-ийн Удирдлагын үнэлгээ, түүнийг олон нийтэд зарлах
- Захирал, аудиторыг томилох тухай санал, дэд захирлын томилгоог батламжлах
- Орон нутаг дахь салбаруудыг байгуулах, татан буулгах
- Үндсэн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах
- Урт хугацаатай зээл авах, бонд гаргах, эргэн төлөлтийн төлөвлөгөө
- Ашиг, алдагдлын хувиарлалт
- Бусад компанид хөрөнгө оруулах
- Дүрэмд өөрчлөлт оруулах
- Дүрэмд заасан журмыг батлах, өөрчлөх, хүчингүй болгох
- Удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал

Удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл аудитораас KBS-тэй холбоотой асуудлаар аудит хийх хүсэлтийг гаргаж болно.

**Гүйцэтгэх байгууллага**

KBS нь гүйцэтгэх байгууллагатай байх бөгөөд захирал, хоёр хүртэлх дэд захирал, найм хүртэлх хэлтсийн дарга, нэг аудитораас бүрдэнэ.

- Захирлыг Удирдах зөвлөлийн санал болгосноор томилгооны сонсголд оруулж ерөнхийлөгч томилно. Удирдах зөвлөл нь захирлыг санал болгохдоо санал болгосон үндэслэл, шалгуурыг тодорхой тайлбарлана.
- Аудиторыг Удирдах Зөвлөлийн санал болгосноор Солонгосын Харилцаа, холбооны хорооноос томилно.
- Дэд захирал болон хэлтсийн даргыг захирал томилох бөгөөд Удирдах зөвлөлийн зөвшөөрлөөр дэд захирлыг томилно.
- KBS-ийн ажилтнуудыг Үндсэн дүрэм заасны дагуу захирал томилж, чөлөөлнө.

**Гүйцэтгэх байгууллага нь дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:**

- Захирал нь KBS-г төлөөлж, KBS-ийн бүх үйл ажиллагааг удирдан зохицуулж, үйл ажиллагааны үр дүнгийн хариуцлагыг хүлээнэ.
- Захирал тодорхой шалтгааны улмаас үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дэд захирал, хэрэв дэд захирал мөн адил шалтгаанаар үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон бол Дүрэмд заасан хүн орлоно.
- Захирал Дүрэмд заасны дагуу KBS-ийн үйл ажиллагаатай холбоотой шүүхийн болон шүүхийн бус аливаа үйл ажиллагаанд төлөөлөх төлөөлөгчийг томилж болно.



- Аудитор нь KBS-ийн үйл ажиллагаа болон санхүү тайлан бүртгэлд хяналт хийнэ.
- Захирал болон аудитор нь Удирдах зөвлөлийн хуралд оролцож санал бодлоо илэрхийлж болно.

### ***Удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх байгууллага, Ажилтны албан үүргийн тухайд***

***Удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх байгууллага нь KBS-тэй хэлцэл хийж болохгүй.*** Мөн Удирдах зөвлөлийн гишүүд нь өөрсдийн болон Иргэний хуулийн 777 дугаар зүйлд заасан гэр бүл, төрөл садангийн холбоотой хүмүүсийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх үйл явцад оролцохыг хориглоно.

KBS-ийн Гүйцэтгэх байгууллага болон ажилтнууд нь үндсэн ажлаас гадна хувийн ашиг хонжоо олох зорилгоор өөр ажил эрхлэхийг хориглоно.

Гүйцэтгэх байгууллага, ажилтнууд болон өмнө нь ажиллаж байсан хэн ч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа олж мэдсэн KBS-ийн нууцыг задруулах буюу хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахыг хориглоно. Хэрвээ ажил үүргээ гүйцэтгэж байхдаа олж мэдсэн нууцыг задруулсан, хулгайлсан этгээдийг ӨНТХ-ийн 105 дугаар зүйлд заасны дагуу 2 жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл 30 сая вон хүртэлх мөнгөн дүнгээр торгууль ногдуулна.

### **Аудит**

KBS-ийн аудитыг дотоод аудит ба хөндлөнгийн аудит гэж хуваана.

- Дүрэм заасны дагуу дотоод аудитыг байгууллагын аудитор гүйцэтгэнэ.
- Хөндлөнгийн аудитыг Хяналт, шалгалтын зөвлөлийн хуульд заасны дагуу Хяналт шалгалтын зөвлөл явуулна.

### **Санхүүжилт**

Байгууллагын санхүүгийн жил нь засгийн газрын санхүүгийн жилтэй адил байна.

KBS-ийн үйл ажиллагааны зардлыг ӨНТХ-ийн **64-р зүйлд заасан телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төлбөрөөс** санхүүжүүлнэ. Хэрэв үндсэн зорилтот үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл **Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон** зар сурталчилгааны орлого болон бусад төрлийн орлогоос нэмэлт санхүүжилт авч болно.

Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон ӨНТХ-ийг хэрэгжүүлэх тогтоолын 36-р зүйлд заасны дагуу "Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон орлого"-д дараах орлогууд багтана. Үүнд:

1. Телевизийн зар сурталчилгааны орлого
2. Телевизийн нэвтрүүлгийн борлуулалтаас олсон ашиг
3. ӨНТХ-ийн 54-р зүйлийн 2 дахь хэсэг эсвэл 61-р зүйлийн дагуу олгогдсон Засгийн газрын санхүүжилт
4. Тусламжийн орлого





5. Хиймэл дагуулын телевиз зэрэг шинэ мэдээллийн хэрэгслээс олсон орлого
6. Дамжуулалтын үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой орлого
7. Бонд эсвэл зээлийн хөрөнгө
8. Өмнөх жилийн шилжүүлсэн үлдэгдэл
9. Бусад нэвтрүүлгийн үйл ажиллагааны орлого

**Санхүүгийн тайлан:** Захирал нь тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 2 сарын дотор өнгөрсөн жилийн санхүүгийн тайланг БНСУ-ын Харилцаа, холбооны хороонд (방송통신위원회) хүргүүлэх ёстой.

**Санхүүгийн тайланд дараах материалууд, баримт бичгийг хавсаргана.**  
**Үүнд:**

1. Санхүүгийн тайлан, дагалдах баримт бичиг
2. Тайлангийн агуулгыг тодорхой болгоход шаардлагатай Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад баримт бичиг

БНСУ-ын Харилцаа, холбооны хороо нь санхүүгийн баримт бичгүүдийг жил бүрийн 3-р сарын 31-ний дотор Хяналт шалгалтын зөвлөлд ирүүлнэ. Хяналт шалгалтын зөвлөл нь санхүүгийн тайлангийн баримт бичгүүдийг шалгаж, үр дүнг 5-р сарын 20-ны дотор БНСУ-ын Харилцаа, холбооны хороонд хүргүүлнэ. БНСУ-ын Харилцаа, холбооны хороо нь Хяналт шалгалтын зөвлөлөөс хийсэн шалгалтын дүнг санхүүгийн материалуудын хамт 5-р сарын 31-ний дотор Үндэсний Ассемблэйд хүргүүлнэ. Санхүүгийн тайланг Үндэсний Ассемблэй баталгаажуулснаар KBS-ийн захирал олон нийтэд мэдээлнэ.

**Төсөв:** KBS-ийн төсвийг захирал боловсруулж, Удирдах зөвлөлийн шийдвэрээр батална. Төсөв батлагдсаны дараа үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх эсвэл зайлшгүй шалтгаанаар төсвийг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд мөн адил Удирдах зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулна. Захирал нь байгалийн гамшиг болон бусад зайлшгүй шаардлагаар тухайн санхүүгийн жил эхлэхээс өмнө төсөв батлагдаж амжаагүй тохиолдолд өмнөх жилийн төсвийг баримтлан түр хэрэгжүүлж болно. Энэ тохиолдолд түр төсвөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан төсөвт багтсан гэж үзнэ.

Төсөв батлагдмагц Удирдах зөвлөлийн шийдвэрээр тухайн санхүүгийн жилийн төсөвт үндэслэсэн **үйл ажиллагааны төлөвлөгөөг** даруй боловсруулж батална. Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталснаас хойш 2 сарын дотор Солонгосын Харилцаа, холбооны хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Төр нь төсвийн хүрээнд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон журмын дагуу байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай зардлын тодорхой хэсгийг санхүүжүүлэх, эсвэл санхүүгийн зээл олгох боломжтой. Мөн байгууллагын гаргасан бондыг худалдан авч болно.

#### **Үйлчилгээний төлбөр**

|                                                    |                 |
|----------------------------------------------------|-----------------|
| <b>БНСУ-ын KBS-ийн үйлчилгээний 1 сарын төлбөр</b> | <b>2500 вон</b> |
|----------------------------------------------------|-----------------|



**ӨНТХ-ийн 64-р зүйл (Телевизийн хүлээн авагчийн бүртгэл болон үйлчилгээний төлбөр)**

Телевизийн нэвтрүүлэг хүлээн авах зорилгоор телевизийн хүлээн авагч эзэмшиж буй этгээд нь Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон журмын дагуу тухайн хүлээн авагчийг холбогдох байгууллагад бүртгүүлж, телевизийн хүлээн авалтын үйлчилгээний төлбөр төлөх үүрэгтэй. Гэхдээ зарлигаар тогтоосон тодорхой төрлийн хүлээн авагчид бүртгэлээс чөлөөлөгдөх эсвэл үйлчилгээний төлбөрийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хөнгөлж болно.

ӨНТХ-ийн 65-р зүйлд заасны дагуу Удирдах зөвлөл үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэлэлцэн тогтоож, БНСУ-ын Харилцаа, холбооны хороогоор дамжуулан Үндэсний Ассемблей баталснаар KBS ногдуулж, хураан авна.

ӨНТХ-ийн 66-р зүйлд заасны дагуу үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд, төлбөрийн 5%-иас хэтрэхгүй хэмжээний алдангийг Ерөнхийлөгчийн тогтоосон хэмжээтэй тохируулан тооцно. ӨНТХ-ийн 64-р зүйлд заасны дагуу хүлээн авагчаа бүртгүүлээгүй этгээдээс 1 жилийн үйлчилгээний төлбөртэй тэнцэх хэмжээний нэмэгдэл хураамж ногдуулан хураан авна. Үйлчилгээний төлбөр, алданги, нэмэгдэл хураамжийг хугацаанд нь төлөөгүй бол БНСУ-ын Харилцаа, холбооны хорооны зөвшөөрлөөр **Үндэсний татварын тухай хуулийн** дагуу хураан авч болно.

KBS тв нь **Korea Educational Broadcasting Corporation (EBS)** гэсэн Солонгосын боловсролын олон нийтийн тв-тэй. Энэхүү тв нь бүх насны хүүхдийн боловсролд зориулагдсан хөтөлбөртэйгөөр үйл ажиллагаагаа явуулдаг тв юм.

ӨНТХ-ийн 68-р зүйлд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон хэмжээний дагуу *алданги болон нэмэгдэл хураамжийг* Солонгосын Боловсролын олон нийтийн тв-ийн тухай хуулийн дагуу EBS тв-ийн санхүүгийн эх үүсвэр болгон дэмжиж болно.

***KBS-ийн үйлчилгээний төлбөртэй холбоотой үүсч буй цаг үеийн асуудал***

ӨНТХ-ийн дагуу KBS-ийн 9/үндсэн суваг/ болон 7 дугаар сувгийг үзэхийн тулд бүх айл өрхүүд үйлчилгээний төлбөрийг төлөх ёстой. Гэвч телевизоргүй, эсвэл KBS-г үздэггүй гэх шалтгаанаар үйлчилгээний төлбөрийг тусад нь авахаар болсон ч төлбөр төлөхгүй айл өрхүүд олон болсон.

2021 оноос өмнө 40 гаруй жилийн хугацаанд(**Нэгдсэн байдлаар хураах систем**) KBS-ийн үйлчилгээний төлбөрийг заавал төлөх цахилгааны төлбөр, сөхийн төлбөрийн хамт шууд авдаг байсан. Гэвч KBS-ийн удирдлагуудын цалингийн нэмэгдэл, менежментийн зардал, хөтөлбөр боловсруулалтын хэт их зардал зэрэг асуудлуудаас санхүүгийн алдагдал үүссэн. Тиймээс 2021 онд ӨНТХ-д өөрчлөлт оруулж, үйлчилгээний төлбөрийг хураах системийг өөрчилж тусад нь бие даан өөрсдөө төлүүлэхээр болсон.

Гэвч шинэчлэл хийгдсэнээс хойшхи 3 жилийн хугацаанд бүх өрхүүд үйлчилгээний төлбөрийг төлөөгүйгээс үүссэн санхүүгийн алдагдал нь KBS телевиз



ажилчид, сурвалжлагчдын цалинг олгох, драма, мэдээллийн хөтөлбөр зэргийг бэлтгэж чадахгүйд хүргэж улмаар KBS-ийн нөхцөл байдал хүндэрсэн байна.

Иймд ӨНТХ-д нэмэлт өөрчлөлт оруулахаар Үндэсний ассемблейгаас ажиллаж байсан бөгөөд БНСУ-ын гол 2 нам эсрэг байр суурьтай байсан хэдий ч 2024.12.02-ны өдрийн Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны байнгын хорооны хуралдаанаар KBS-ийн үйлчилгээний төлбөрийг **“нэгдсэн байдлаар хураах тухай”** Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ардчилсан намын 12 гишүүн дэмжиж, Ардын хүч намын 6 гишүүн эсэргүүцэж байнгын хороогоор дэмжигдсэн байна.

### **Хөтөлбөр**

ӨНТХ-ийн 69-р зүйлд заасны дагуу KBS нь Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу үзэгчдийн шууд боловсруулсан үзэгчдийн оролцоотой хөтөлбөрийг оруулах ёстой.

Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон ӨНТХ-ийг хэрэгжүүлэх тогтоолын 51-р зүйлд “Үзэгчдийн оролцоотой хөтөлбөр”-ийн талаар хуульчилж өгсөн.

- KBS нь өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй сувгуудад сард дор хаяж 100 минутын турш үзэгчдийн боловсруулсан үзэгчдийн оролцоотой нэвтрүүлгийг хөтөлбөртөө оруулах үүрэгтэй.
- KBS нь үзэгчдийн оролцоотой хөтөлбөрүүдийг гаргах цагийг тодорхойлж, түүнийг олон нийтэд зарлах ёстой.
- Үзэгчдийн оролцоотой хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн дэмжлэг болон өргөн нэвтрүүлгийн эрх зэрэг шаардлагатай асуудлуудыг БНСУ-ын Харилцаа, холбооны хорооны дүрэмд зааснаар зохицуулна.

### **Контент**

KBS-ын 2022-2024 оны Дунд болон ур хугацааны төлөвлөгөөнд контентын талаар дараах байдлаар тусгасан байна.

**Хөгжүүлэх чиглэл:** Өндөр чанартай, томоохон хэмжээний соёлын баримтат кино болон төрөл бүрийн түүхийн контентуудыг бүтээж, БНСУ-ын контентын түвшин болон үнэлэмжийг бататгах.

### **Үйл ажиллагааны төлөвлөгөө:**

#### **А. Томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэх**

- Дэлхийн жишигт нийцсэн, өндөр чанартай баримтат киноны цувралаар дамжуулан төрөл бүрийн контент хүргэх.
- Түүхэн контентыг төрөлжүүлэх, гүнзгийрүүлэх замаар нийтийн үнэ цэнийг бодитоор нэмэгдүүлэх.
- Өндөр чанартай шинжлэх ухаан, анагаах ухааны баримтат киноны цуврал бүтээх.
- Байгаль, цаг уурын өөрчлөлтийн тухай тусгай баримтат киноны цувралыг чанарын өндөр түвшинд бүтээх.
-



### **Б.Өндөр чанартай драмын бүтээл**

- Уламжлалт түүхэн жүжгүүдийг бүтээж, Солонгосын үндэсний identity-г бататгахад хувь нэмэр оруулах.
- Тогтмол хуваарьт ганц үзэгдэлт жүжгийг бүтээх замаар үйлдвэрлэлийн экосистемийн олон талт байдлыг бий болгох.

### **В. Ард түмний сэтгэлд хүрсэн тусгай эвентийн бүтээл**

- Ард түмний сэтгэлд хүрэх өндөр чанартай тоглолтын хөтөлбөрүүдийг бүтээх.

### **Г.Дижитал радио контентын өргөтгөл**

- Өндөр чанартай олон платформ контент бүтээх.
- KBS Classic FM-ийн соёл, урлагийн тусгай хөтөлбөрийг бүтээх.

### **Д.Спортын томоохон арга хэмжээг амжилттай нэвтрүүлэх /Жишээлбэл, олимп/**

- Спортын томоохон арга хэмжээний шууд дамжуулалтаар Солонгосын олон нийтийн суваг болох KBS-ийн статус, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх

**Дүгнэлт:** БНСУ-ын олон нийтийн тв болох KBS нь байгуулагдаад өдгөө 97 дахь жилдээ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна. KBS нь бусад тв-тэй харьцуулахад төрөл бүрийн чиглэлээр хөтөлбөрөө явуулдаг нь олон нийтийн шинжээс гадна KBS-ийн ялгах гол онцлог нь юм. Тодруулбал, БНСУ-ын ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг өргөн нэвтрүүлгүүд нь зөвхөн спорт, амьтан гэх зэргээр тусгай зөвшөөрөл авсан тухайн чиглэлээрээ л дагнан ажилладаг. Ийм учраас KBS нь мэдээллийн хөтөлбөрүүдээс эхлээд хөгжим, драм, түүхэн болон соёл урлагийн зэрэг олон чиглэлээр хөтөлбөрөө нэвтрүүлдэг тул үзэгчдийн үзэх гол эх сурвалж болдог байна. KBS1 нь нийгмийн асуудлууд, мэдээ мэдээлэл, боловсролын хөтөлбөрүүдийг голчлон хүргэдэг бол KBS2 нь энтертайнмент болон амьдралын хэв маягийн нэвтрүүлгүүдээрээ алдартай. Үүнээс гадна KBS World нь олон улсын үзэгчдэд зориулсан 12 хэлээр нэвтрүүлгээ бэлтгэдэг нь KBS-ийн хүрч ажиллах чадварыг нэмэгдүүлдэг байна.

Энэхүү системийн онцлогийг Монгол улстай харьцуулахад Монгол улсын хувьд бусад ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй өргөн нэвтрүүлгүүд нь зөвхөн нэг чиглэлээр бус олон чиглэлээр хөтөлбөрөө түгээж байгаагаас үзвэл системийн онцлог нь Монгол улсаас ихээхэн ялгаатайг харуулж байна.

Засаглалын тухайд KBS-ийн удирдах дээд байгууллага болох Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт орон тооны бус 11 гишүүнтэй бөгөөд гишүүдийг БНСУ-ын Харилцаа, холбооны хорооноос санал болгож Ерөнхийлөгч 3 жилийн хугацаатайгаар томилдог бол Монгол улсын хувьд ОНРТ-ийн удирдах дээд байгууллага болох Үндэсний зөвлөл нь нийт 15 орон тооны бус гишүүнтэй, иргэний нийгмийн төлөөллөөс Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газарт санал болгосноор 6 жилийн хугацаатайгаар УИХ томилдог. Үүнээс үзвэл, БНСУ нь Ерөнхийлөгчийн засаглалтай орон тул томилгоонд Ерөнхийлөгч Монголтой харьцуулахад давамгайлж байна. Мөн гишүүдийн тооны хувьд БНСУ 50 сая гаруй хүн амтай ч 11 гишүүнтэй байхад Монгол 3 сая гаруй хүн амтай ч 15 гишүүнтэй байгаа нь гишүүдийн



тооны харьцааг анхаарч үзэх шаардлага байж магадгүйг харуулж байна. Гишүүдийг БНСУ нь Монголоор Харилцаа, холбооны зохицуулах хороо нь санал болгож байгаа бол Монголын хувьд иргэний нийгмийн төлөөлөл санал болгож байгаа нь 2 талын тус тусын ялгагдах онцлог гэж харж болохоор байна.

Санхүүжилтийн тухайд БНСУ болон Монгол улс ижил төстэй байна. Контентын тухайд дээр өгүүлсэнчлэн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааны системийн онцлогоос ихээхэн хамаарч байна.

---oOo---